75	Ирээдүй цогцолбор хорооллын дулааны 4100 м гол шугам, 6 ширхэг дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	9,267.0	2,537.4
76	Ирээдүй цогцолбор хорооллын 2 дугаар ээлжийн бохир усны ф 150-450 мм-ийн голчтой 2200 м гол шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	406.0	203.0
77	Ирээдүй цогцолбор хорооллын 2 дугаар ээлжийн 2*630 кВА чадалтай ТП 1 иж бүрдэл, 5 км урт 10 кВ-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	552.0	331.2
78	VII хорооллын 12 хэсгийн 6 ширхэг ус, дулаан дамжуулах төвийн барилга, гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	1,633.0	1,633.0
79	110/35/10 кВ-ын 2х40 МВА "XIV хороолол" дэд станцын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	9,161.0	765.0
80	14 дүгээр хороолол, Зүүн хүрээ хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кВ-ын түгээх сүлжээнд 22.0 МВт чадлын хэрэглээг хангах 10 кВ-ын ХБ 4 иж бүрдэл, ХТП 18 иж бүрдэл, 10 км урт 10 кВ-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	6,561.0	1,199.4

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
81	14 дүгээр хорооллын дэд станцаас 10 кВ-ын 4 иж бүрдэл хуваарилах байгууламж руу татах 5 км, 22.0 МВт чадлын хэрэглээг хангах кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	587.0	143.8
82	Орон сууцны 14 дүгээр хорооллын ф 125-300 мм-ийн 4.57 км дулааны шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	3,063.8	1,850.7
83	Орон сууцны 14 дүгээр хорооллын 4 ширхэг ЦТП, ф 100-250 мм-ийн 3.34 км цэвэр усны шугам, 4 ширхэг насос станц, усан сангийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	1,987.0	729.9
84	Орон сууцны 14 дүгээр хорооллын ф 150-300 мм-ийн 1.87 км бохир усны шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	422.0	152.8
85	МҮОНРТ орчмын хорооллын 6 хэсгийн 6 ширхэг ус, дулаан дамжуулах төвийн барилга, гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	1,633.0	489.9
86	Берлин эко орон сууцны хорооллын дунд баригдах "Буянт-Ухаа" 2х40 МВА 110/10 кВ-ын дэд станц, 2.5 км урт 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	13,915.0	8,462.1
87	"Солонго" орон сууцны хорооллын гадна цэвэр усны шугам өргөтгөх, бохир усны гол шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	529.0	529.0
88	"Солонго" орон сууцны хорооллын гадна цахилгааны 110/35/10 кВ-ын "Цэвэрлэх" дэд станцын 10 кВ талын өргөтгөл, 2 ком 10 кВ-ын хуваарилах байгууламж, 10 кВ-ын кабель шугам 19.5 км, 10/0.4 кВ-ын 2х630 кВА-ын 12 ХТП-ний зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	6,266.0	470.6
89	"Солонго" орон сууцны хорооллын гадна дулааны шугам өргөтгөх, 43.53 ГКал/цагийн ачаалалтай дулааны шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	2,300.0	1,840.0
90	"Шинэ Яармаг" хорооллыг дулаанаар хангах Пумагаас баруун тийш 2 ф 500-2 ф 300 мм-ийн голчтой дулааны шугам 2.5 км, "Дулааны цахилгаан станц 4"-өөс Яармагийн гэр хороолол хүртэл 2ф 600/700 мм голчтой дулааны шугам 2450 метр, 150 м гүүрэн тулгуур, "Дулааны цахилгаан станц 4"-ийн коллектор станцын өргөтгөл, "Дулааны цахилгаан станц 4"-ийн 210 МВт дулааны дэд станцыг хотын сүлжээтэй холбох ф 1000 мм-ийн голчтой дулааны шугам 1.3 км, "Дулааны цахилгаан станц 4"-ийн шинэ коллектор станц, Яармагийн зам доогуур хөндлөн гарах нийт 360 м урт 6 ширхэг хонгилын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	31,970.0	13,483.0
91	"Яармаг" орон сууцны хорооллын 15.0 км цэвэр усны гол шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	4,560.0	4,560.0
92	"Яармаг" орон сууцны хорооллын 14.5 км бохир усны гол шугам, насос станцын барилга, гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	2,911.0	2,133.4



№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
93	"Яармаг" орон сууцны хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кВ-ын түгээх сүлжээнд ойролцоо тооцоогоор 14.3 МВт чадлын хэрэглээг хангах 10 кВ-ын ХБ 3 иж бүрдэл, 2*400 кВА чадалтай ТП 36 иж бүрдэл, 37.6 км урт 10 кВ-ын кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	8,807.0	5,827.0
94	Яармагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2х25 МВА чадалтай компьютерийн хяналт, удирдлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил, 110 кВ-ын АС-240/39 дамжуулагч утастай, 2х2 км шилэн кабель бүхий аянгын тростой цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	7,291.0	481.5
95	Яармагийн гүүр орчмын хорооллын дэд станцаас 10 кВ-ын 3 иж бүрдэл хуваарилах байгууламж руу татах 12 км, 15 МВт чадлын хэрэглээг хангах кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	1,035.0	968.7
96	Ховд аймгийн төвийн 4200 м <sup>3</sup> хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил	2013	2015	1,500.0	601.9
97	Улаанбаатар хотын дулаан хангамжийн 3 а, б, в гол шугамыг ф 600/500 голчтой болгон өргөтгөх зураг төсөл, барилга угсралтын ажил (Нарантуул зочид буудлын урд талын дулааны худгаас Драмын театрын зүүн хойд худаг хүртэл)	2014	2015	12,650.0	12,650.0
98	"Дулааны цахилгаан станц 4"-өөс "У-18" хүртэл (Москва хорооллын урд тал хүртэл) 4.2 км ф 800-гийн голчтой дулааны шугамын барилга угсралтын ажил	2014	2015	14,490.0	1,915.4
99	Насосны станц 8-ын өргөтгөлийн барилга угсралтын ажил	2014	2015	887.0	887.0
100	Байшин үйлдвэрлэх комбинат 2-оос ТК 844 хүртэл 2 ф 400, 2 ф 800 мм-ийн 2000 метр шугамын өртгөтгөлийн барилга угсралтын ажил ("Дулааны цахилгаан станц 4")	2014	2015	6,958.0	169.5
101	Зуух №9-ийг сэргээн засварлах ("Дулааны цахилгаан станц 3") барилга угсралтын ажил	2014	2015	11,400.0	651.6
102	Амгалан дулааны станцаас дулаан түгээх цэг хүртэлх 2 ф 700 мм-ийн 4 км шугамын барилга угсралтын ажил	2014	2015	14,000.0	1,146.4
103	Цахилгааны хаалттай дэд өртөө 2х630 кВА 1 ширхэг, 2х800 кВА 3 ширхэг, 3х185-ын 1980 у/м кабель шугамын барилга угсралтын ажил	2014	2015	819.0	819.0
104	Дулаан хангамжийн эх үүсвэр, уурын зуухны барилга-2 ширхэг, хатуул түлшний халаалтын тогоо-6 ширхэг, хэрэгцээний халуун усны ялтсан солилцуур-2 ком -ын барилга угсралтын ажил	2014	2015	873.0	873.0
105	Дулааны шугам сүлжээний ф 80/200 мм-ийн голчтой шугам 738 метр, ф 50/150 мм-ийн голчтой шугам 2410 м-ийн барилга угсралтын ажил	2014	2015	1,003.0	1,003.0
106	Цэвэр усны ф 32/150 мм-ийн голчтой 1400 м шугамын барилга угсралтын ажил	2014	2015	182.0	182.0
107	Бохир усны ф 150/200 мм-ийн голчтой 800 м шугамын барилга угсралтын ажил	2014	2015	132.0	132.0

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
108	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын 4 ширхэг ус дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажил	2014	2015	1,600.0	480.4
109	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын дулааны 2 ф 300/400 мм-ийн голчтой 1.1 км шугам, 1 ширхэг ус дулаан дамжуулах төв, ф 150мм-ийн голчтой 137 м шугам, бие даасан 9.3 Гкал чадалтай дулааны эх үүсвэр, гадна төв бохир усны ф 500 мм-ийн 1235 м шугам, бохир усны ф 200-300 мм-ийн 1788 м шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	9,854.0	4,139.7
110	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын цахилгааны хаалттай дэд өртөө (ХТП)-г 14 комплект, 10 кВ-ын 28 км кабель шугам тавих, 10кВ-н ХБ 1 ком барих барилга угсралтын ажил	2014	2016	6,050.3	524.2
111	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын цэвэр усны ф 100/300 мм-ийн 1812 м шугамын барилга угсралтын ажил	2014	2016	1,009.0	215.6
112	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын бохир усны ф 150-300 мм-ийн 1441 м шугамын барилга угсралтын ажил	2014	2015	399.0	200.5
113	Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны гэр хорооллын дулаан хангамжийн эх үүсвэрийг өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	2014	2016	6,100.0	2,546.1
114	Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны гэр хорооллын дулааны ф 80-300мм-ийн 2 км шугамыг өргөтгөн шинэчлэх, шинээр барих барилга угсралтын ажил	2014	2015	8,880.0	1,297.2
115	Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны гэр хорооллын цахилгааны 4 ширхэг, 9 ширхэг хаалттай дэд өртөө барьж байгуулах, өндөр хүчдэлийн 5900 м кабель шугамын хамт өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил	2014	2016	7,540.0	1,528.6
116	Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны гэр хорооллын цэвэр усны ф 80-300 мм-ийн 4 км шугамын барилга угсралтын ажил	2014	2015	930.0	333.4
117	Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны гэр хорооллын бохир усны ф 200-400 мм-ийн 8.22 км шугамын барилга угсралтын ажил	2014	2015	580.0	232.5
118	Дулааны ф 65/200 мм-ийн голчтой 924 м шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	358.2	358.2
119	Усан хангамж ф 32/150 мм голчтой 871 м шугам, ариутгах татуургын ф 150/300 мм-ийн голчтой 3100 м шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	557.7	557.7
120	10кВ-ын ХТП-2 ширхэг, цахилгааны 10 кВ-ын 1.5 км кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2016	580.0	478.5
121	Холбооны 2 яндантай 2100 метр сувагчлалын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2015	252.0	252.0
122	Амгалан дулааны станцаас дулаан түгээх цэг хүртэлх 2 ф 700 мм-ийн голчтой 4 км шугамын барилга угсралтын ажил	2014	2016	6,522.0	5,789.2

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
123	Амгалан дулааны станцын ахуйн хэрэгцээний цэвэр усан хангамжийн угсралтын ажил	2014	2015	228.0	228.0
124	Шар хад, Амгалан орчмын бохир ус татан зайлуулах, ариутгах татуургын шугам сүлжээний ажил	2014	2015	2,224.0	2,224.0
125	220 кВ-ын Улаанбаатар дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станц хүртэлх 110 кВ-ын 9.7 км 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил	2014	2015	938.4	311.9
126	110 кВ-ын Баянгол дэд станцаас 110 кВ-ын Радио телевиз дэд станц хүртэлх 110 кВ-ын 24 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014	2015	814.9	394.1
127	220 кВ-ын Сонгино дэд станцаас 110 кВ-ын Зайсан дэд станц хүртэлх 110 кВ-ын 50 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014	2015	2,139.7	993.5
128	110/35/10 кВ-ын 2*40 МВа дэд станцаас 14-р хорооллын дэд станцын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам хүртэлх 110 кВ-ын 2 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014	2015	2,100.0	753.1
129	"Сонгино" 220/110/35 кВ-ын 2х125 МВА дэд станц, 220 кВ-ын 10 км цахилгаан дамжуулах агаарын шугам (Улаанбаатар)	2014	2015	4,698.0	2,636.2
130	Онцгой байдлын албаны командын байрны барилга, техник, тоног төхөөрөмж	2015	2015	20,000.0	20,000.0
131	Баянголын амны "Баянгол" хорооллын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 2.2 км, дэд станц, 110/35/10 кВ, 2х40МВА (Улаанбаатар)	2014	2015	2,291.0	1,067.5
132	Баянгол дүүрэг, Гандан Орхоны 10 дугаар гудамжны шинэчлэлт, барилгын ажил	2014	2015	381.6	67.6
133	Гандан тэгчилэн хийд орчмын гэр хорооллын нөхцлийг сайжруулах дэд төслийн хүрээнд Орхоны 10-р гудамжны зам барилгын ажил	2014	2015	197.1	197.1
134	Баянгол дүүрэг, Гандан Орхоны 5 дугаар гудамжны дэд бүтцийн ажил	2014	2015	655.8	98.7
135	Гандангийн Орхоны 6 дугаар гудамжны шинэчлэлт, барилгын ажил	2014	2015	284.4	51.1
136	Ховд-Улаангом чиглэлийн авто зам зураг 190 км	2013	2015	458.4	7.1
137	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто зам барилга 100 км	2013	2016	23,276.4	1,248.5
138	Халзанбүргэдэй-Солонготын даваа чиглэлийн авто зам 100 км "Монроуд" ХХК	2014	2016	23,177.2	12,580.6
139	Сэлэнгэ мөрний Сацын булангийн төмөрбетон гүүр	2014	2016	4,104.2	1,219.7
140	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын барилга 10.65 км	2013	2015	1,900.0	176.3
141	Өндөрхаан-Мөнххаан-Баруун урт чиглэлийн авто зам 132.6 км	2014	2015	20,038.4	4,536.2
142	Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн авто замын барилга 60 км	2014	2015	12,811.3	9,832.6
143	Цагаан-Үүр сумын Үүрийн голын төмөр бетон гүүр	2013	2015	384.4	367.4
144	Лүн-Эрдэнэсант-Арвайхээр а0301 авто замын засвар	2013	2016	2,636.0	173.3

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
145	Орон нутаг-Багануур-Улаанбаатар-Зуунмод а0201 чиглэлийн авто зам "Баянчандмань АЗЗА" ТӨХК	2013	2016	7,559.0	452.9
146	Өндөрхаан-Мөнххаан-Баруун урт чиглэлийн авто замын хяналт 132.6 км	2014	2015	1,000.6	371.8
147	Цахир-Тосонцэнгэл чиглэлийн авто зам хяналт 127.1 км	2014	2015	1,000.0	1,000.0
148	Цахир-Тосонцэнгэл чиглэлийн авто зам барилга 127.1 км	2014	2016	34,899.9	15,845.9
149	Шарга морьт – Жигжидийн уулзвараас Гүнтийн даваа чиглэлийн 5 км авто замын ажил	2013	2015	1,019.8	167.9
150	"Магнай трейд"-ын шатахуун түгээх станцын уулзвараас Хайлаастын эцэс хүртэлх 3,1 км авто зам	2013	2015	1,749.7	326.8
151	Шинээр барих зүүн хэсгийн туслах гудамж зам /Нарны замаас Амгалан руу Энхтайваны өргөн чөлөөтэй холбох 3.3 км авто зам/ /Цайз захын зүүн талын хойшоо явах 0.5 км авто зам/ /Улаанхуарангийн эцсээс урагш Энхтайвны өргөн чөлөө хүртэлх 0.8 км авто зам/	2013	2015	17.8	7.0
152	Далангийн шинэ замаас хогийн цэг хүртэлх 1.2 км авто замын зураг төсөл	2013	2015	9.6	9.6
153	Баруун талаас буюу шинэ хотын төвөөс төмөр замын урдуур ТЭЦ 4-н авто замтай холбогдсон 14 км авто замын зураг төсөл	2013	2015	98.0	98.0
154	Баянголын авто замын баруун талаас 22-н товчооны баруун талын гарц хүртэлх авто замын зураг төсөл	2013	2015	62.4	62.4
155	Багахангай дүүрэг, Багахангай өртөөнөөс Улаанбаатар-Чойр чиглэлийн авто зам хүртэлх 1.9 км авто замын зураг төсөл	2013	2015	14.2	14.2
156	Баянголын амны 4 дүгээр ээлжийн дулааны ажил	2013	2015	2,925.8	126.7
157	Шинээр тавихаар төлөвлөж байгаа төмөр замын дагуу GPS-ийн сүлжээ байгуулах, 1:25000 масштабтай байр зүйн зураглал хийх /11 аймаг/	2011	2016	14,140.2	1,500.0
158	Аймаг, дүүргийн доторх гудамж, зам, талбайн тохижилт, шинэчлэл /Улаанбаатар, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Ховд/	2015	2016	5,450.0	2,323.4
159	Нийтийн зориулалттай орон сууцын цахилгаан шатны шинэчлэл, засварын цех /Улаанбаатар/	2013	2016	13,000.0	1,757.7
160	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хөвсгөл, Мөрөн сум/	2013	2016	5,000.0	648.1
161	Төв аймгийн шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах /Төв/	2014	2016	3,940.0	1,061.5
162	Умард дэд станцаас кабель шугам татаж 6 дугаар бичил хороололд шинээр 10 кВ-ын хуваарилах байгууламж барих /Улаанбаатар/	2014	2016	2,420.4	710.2
163	35/6 кВ-ын Баянхошуу 2х10 МВА чадалтай шинэ дэд станц барьж, 35 кВ-ын 7.2 км 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам татах /Улаанбаатар/	2014	2016	2,021.1	610.6
164	Явган хүний 10 ширхэг гүүр, авто тээврийн гүүр 1 ширхэг зураг төсөл, барилгын ажил /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2015	2016	1,200.0	1,033.1
165	Хотын зам, тохижилт, ногоон байгууламж /Өвөрхангай, Арвайхээр сум/	2014	2016	2,000.0	145.0

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
166	Дэд бүтцийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2014	2016	5,629.0	916.3
167	Улаанбаатар хотын төвийн 6, 10 кВ-ын кабель шугамын шинэчлэлт /Улаанбаатар/	2014	2016	6,000.0	1,552.1
168	Үйлдвэрийн районы 35 кВ-ын 35/6 кВ-ын 2х6300 кВА дэд станц, 35 кВ-ын хуурай салгуурын пунктын өргөтгөл /Дархан-Уул/	2014	2016	3,997.8	998.9
169	Аймгийн төвийн 6 кВ-ын цахилгаан хуваарилах байгууламжийн шинэчлэл /Баян-Өлгий,Өлгий сум/	2015	2016	1,578.1	1,115.0
170	Наадмын талбайн дуусгал, 2500 суудал /Увс, Улаангом сум/	2011	2015	4,200.0	2,000.0
171	Аймгийн төвийн автозамын дуусгалт, 5.87 км /Орхон, Баян-Өндөр сум/	2013	2016	1,581.7	291.4
172	Аймгийн төвийн автозамын үлдэгдэл санхүүжилт 5.08 км /Орхон, Баян-Өндөр сум Дэнж баг/	2013	2016	1,895.8	259.8
173	Газар хөдлөлийн гамшгийн эрсдлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах	2013	2016	1,680.1	985.9
174	Мянгадын гүүрээс Сархайран чиглэлд барих 20 км хатуу хучилттай авто замын ажил /Ховд/	2012	2016	8,388.7	2,693.5
175	Сумын төвийн гэрэлтүүлэг, авто зам, тохижилт /Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Манхан, Ховд, Мөст, Чандмань сумдад/	2015	2016	2,470.0	1,816.8
176	Хэрлэн голын төмөр бетон гүүр /Хэнтий, Баянмөнх сум/	2011	2016	3,800.0	1,263.7
177	Орбитын уулзвараас Толгойтын эцэс Үйлдвэрчний эвлэлийн гудамж хүртэлх авто замын өргөтгөл шинэчлэл 3.6 км	2015	2016	14,961.5	1,475.1
178	Багануур-Цэнхэрмандалын 35 кВ-ын цахилгаан дамжуулан агаарын шугам, дэд станц /Хэнтий/	2015	2016	3,415.8	313.2
179	12 а магистралийн ТК-1211 цэгээс урагш гарсан 2 ф 400 мм голчтой шугамын 2 ф 500 мм болгон өргөтгөх, 3х500х70 хүчин чадалтай шинээр даралт өргөх насос станц барих, зургийн хамт /Улаанбаатар/	2015	2016	7,296.0	3,992.4
180	5В магистраль Тк-1893-с Континенталь зочид буудлын баруун талын уулзвар хүртэлх 2100 метр 2х500 мм-ийн шугамыг 2х800 мм болгон өргөтгөх /Улаанбаатар/	2014	2016	5,385.5	1,432.8
181	1в магистралийн Тк-1893-с Тк-117 цэг хүртэлх 1500 метр 2х500 мм-ын шугамыг 2х700 мм шугам болгон өргөтгөх /Улаанбаатар/	2014	2016	2,998.6	732.0
182	Багануурын дулааны станцын сүлжээний усны зарцуулалт хувьсах насосны горимд шилжих /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2014	2016	3,100.0	764.7
183	Дулааны цахилгаан станц 2-ын Р-4 /АК-6/ турбины шинэчлэлийн ажил /Улаанбаатар/	2014	2016	2,928.9	714.4
184	Замын-Үүд дэх шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн автоматжуулалт	2014	2016	3,593.0	1,907.1
185	Дулааны станцын КВТС-10/150 зуух барих /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2013	2016	2,981.0	447.3
186	Дулааны станцын дулаан хангамжийн нэгдсэн системийг үл хамаарах схемд шилжүүлэх, үндсэн магистрал шугам сүлжээг шинэчлэх /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2013	2016	3,538.3	773.8

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
187	Төвлөрсөн дулаан хангамжийн шугамын шинэчлэл /Хөвсгөл, Мөрөн сум/	2013	2016	15,253.9	360.1
188	Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах /УБ/	2014	2016	9,000.0	6,213.1
189	Залаат, Бага тэнгэр, Их тэнгэрийн ам, Хан-Уул, Баянзүрх дүүргийн хорооллуудын цахилгаан хангамжийг сайжруулах зорилгоор 110/10 кВ-ын дэд станц, 110 кВ-ын 7.6 км цахилгаан дамжуулах агаарын шугам /УБ/	2014	2016	8,969.3	2,722.9
190	Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагааны 35 кВ-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 110/35/6 кВ-ын дэд станцын өргөтгөл /Сүхбаатар/	2014	2016	8,400.0	2,242.5
191	Хорооллын гадны цахилгаан хангамж 6/0.4 кВ-ын 2х630 кВа ХТП-15 ком, 6кВ-ын 34,9 км кабель шугам /Дархан-Уул, Дархан сум, 11, 12, 24, 25, 26 дугаар хороолол/	2014	2016	9,715.0	6,206.6
192	Хорооллын гадны цахилгаан хангамж 6/0.4 кВ-ын 2х630 кВа ХТП-8 ком, 6 кВ-ын 10,5 км кабель шугам /Дархан-Уул, Дархан сум, 2, 3 дугаар хороолол/	2014	2015	4,969.0	3,469.0
193	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/	2014	2016	17,000.0	7,860.6
194	Мардай-Чулуунхороот сумын 35 кВ-ын 160 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорнод/	2012	2016	4,397.4	3,358.5
195	Дарханы дулааны цахилгаан станцад хаягдал үнсэн сан шинээр барих /Дархан-Уул/	2014	2016	8,147.5	3,084.1
196	Эрчим хүчний төвлөрсөн системд холбох, 3 сум /Дорноговь, Хатанбулаг, Мандах сум, Говь-Алтай, Бугат сум/	2015	2016	11,928.0	6,414.9
197	Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох /улсын хэмжээнд/	2012	2016	15,000.0	2,841.1
198	Инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	2014	2016	4,374.3	1,049.8
199	Цэвэр, бохир усны шугам сүлжээ, усан сан, насосны станц, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар, Багахангай дүүрэг/	2013	2016	7,600.0	3,033.8
200	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид 2 дугаар тунгаагуур 2 ширхэг, биоцөөрөм барих /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2013	2016	8,519.1	3,085.9
201	Аймгийн төвийн 1000 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Дорноговь, Төв, Говьсүмбэр, Булган, Увс, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Сүхбаатар, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Хэнтий/	2013	2016	62,000.0	8,060.8
202	Сумын төвийн шинэчлэл төсөл /Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Өмнөговь, Төв, Увс, Ховд, Хэнтий, Хөвсгөл аймагт тус бүр нэг сум/	2014	2016	80,000.0	7,062.7
203	Элсэн тасархай-Хархорины Орхоны гүүр чиглэлийн 77 км хатуу хучилттай авто замын шинэчлэл /Өвөрхангай/	2012	2016	26,965.1	11,902.3

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
204	Ханх-Мондын чиглэлийн 23 км хатуу хучилттай авто зам /Хөвсгөл, Ханх сум/	2012	2016	14,340.4	2,352.0
205	Мөрөн сумын дунд тойргийн 9.8 км хатуу хучилттай авто замын өргөтгөл /Хөвсгөл, Мөрөн сум/	2012	2016	8,300.0	1,509.0
206	Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээ Засгийн газрын 2015 оны 313, 328 тоот тогтоолын хүрээнд хийгдэх авто зам, гудамж төсөл	2012	2016	122,874.2	11,183.0
207	Гүүр, 4 ширхэг /Сэлэнгэ мөрний төмөр бетон 437.02 у/м гүүр, зураг, төсөл Сэлэнгэ мөрний дөрөө хангинахын хөвдөг гүүр, Дэлгэрмөрөн голын хөвдөг гүүр, бирваазын шинэчлэл, Ерөө голын төмөр бетон гүүр/ /Булган, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн Баянзүрх, Их-Уул сум/	2013	2016	19,242.0	4,402.0
208	Аймгийн төвөөс хилийн боомтууд чиглэлийн хатуу хучилттай авто замуудын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах /Дорнод, Хэрлэн сум, Баянхошуу боомт, Хавиргын боомт, Ульхан боомт/	2015	2016	1,700.0	200.0
209	Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах /Дархан-Уул, Дархан сум/	2014	2015	16,000.0	8,000.0
210	Эгийн голын усан цахилгаан станц /315 МВт/, /Булган аймаг, Хутаг-Өндөр сум/	2013	2016	59,535.0	4,952.6
211	Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр зам	2013	2016	350,000.0	1,837.5
212	Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл	2014	2017	991.9	493.2
213	Эрдэнэс Оюу Толгой	2014	2016	17,045.0	6,060.7
214	Амгалан дулааны станц /348МВт/, Улаанбаатар хот	2014	2016	132,825.0	39,455.7
			<b>214</b>	<b>2,112,885.9</b>	<b>444,655.0</b>

**МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ  
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ  
ДАГАЛДАН ГАРАХ ХУУЛЬ БОЛОН  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСЛҮҮД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны ... дугаар

Төрийн ордон

сарын ...-ны өдөр

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төсвийн тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1. 11 дүгээр зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх хэсэгт 11.1.21 заалт нэмэх:

“11.1.21 Засгийн газраас тусгайлан эрх олгосноос бусад тохиолдолд гадаадын тусламж авах гэрээ, хэлэлцээрт Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 201.. оны .. дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## ТАНИЛЦУУЛГА

*Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл*

Засгийн газрын шугамаар гадаадын зээл, тусламжийн гэрээ хэлэлцээ хийх, байгуулах, батлуулах, хүлээн авах, зохицуулах харилцааг Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулиар зохицуулдаг байсан. Өрийн удирдлагын тухай хууль 2015 онд батлагдсанаар Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хууль хүчингүй болсон ба уг хуулийн 3.5 дахь заалтад “Бүх төрлийн тусламжийн харилцаанд энэ хууль хамаарахгүй” гэж заасан нь тусламжийн харилцааг зохицуулах эрх зүйн орчингүй болсон байна. Хуульд тодорхой зохицуулалт байхгүйгээс Засгийн Газраас гадаад түнш орон, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд гадаадын буцалтгүй тусламжийн гэрээ, хэлэлцээр байгуулахдаа яамдын саналыг авч асгийн газрын хуралдаанд тухай бүр хэлэлцүүлэн гарын үсэг зурах эрхийг төсөл тус бүр дээр авах шаардлага үүсээд байна.

Энэхүү үүссэн асуудлыг одоогийн мөрдөж байгаа Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд “Засгийн газраас тусгайлан эрх олгосноос бусад тохиолдолд гадаадын тусламж авах гэрээ, хэлэлцээрт Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурна” гэсэн нэмэлт оруулснаар шийдвэрлэх боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 3 дахь заалтын “0-252.000” гэснийг “0-452.000” гэж, “0-259.000” гэснийг “0-459.000” гэж, “0-265.000” гэснийг “0-565.000” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## ТАНИЛЦУУЛГА

### *Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл*

Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнийн савлагааг зохицуулж дотоодын автобензин, дизелийн түлшний үнийг тогтвортой байлгах, цаашлаад өргөн хэрэглээний барааны үнийг өсөхөөс сэргийлж автобензин, дизелийн түлшний хилийн үнээс хамааруулан онцгой албан татвар, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээг УИХ-аас баталсан хязгаарт багтаан Засгийн газар тухай бүр тогтоож байна.

УИХ-аас олгосон эрхийн дагуу автобензин, дизелийн түлшний хилийн үнэ өсөх үед Засгийн газраас шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааг зохих түвшинд хадгалан дээрх татваруудыг бууруулах, харин хилийн үнэ буурахад татваруудыг нэмэх зохицуулалтыг тухай бүр хэрэгжүүлж байсны үр дүнд дотоодын зах зээл дэх үнийн огцом өөрчлөлтийг сааруулан, харьцангуй тогтвортой түвшинд хадгалж ирсэн билээ.

Хамгийн сүүлд Засгийн газрын 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 18 дугаар тогтоолоор автобензин, дизелийн түлшинд ногдуулдаг онцгой албан татварын хувь хэмжээг хуульд заасан хамгийн дээд хувь хэмжээгээр буюу 90 хүртэл октантай автобензинд тонн тутамд 252.0 мянган төгрөг, 90-с дээш октантай автобензинд тонн тутамд 259.0 мянган төгрөг, дизелийн түлшинд тонн тутамд 265.0 мянган төгрөг байхаар тогтоогоод байна. Ийнхүү татварын хувь хэмжээг хуулийн хамгийн дээд дүнгээр тогтоосон ч хилийн үнийн бууралтын улмаас шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшин дунджаар 10 гаруй хувиас даваад байна.

Өнгөрсөн оны сүүлийн хагас жилээс эхлэн дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ тогтмол буурч, үүнийг дагаад ОХУ-аас импортоор авдаг автобензин, дизелийн түлшний хилийн үнэ төлөвлөсөн хэмжээнээс буурч байгаа нь аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааг огцом өсгөж байгаа тул УИХ-аас баталсан татварын дээд хувь хэмжээг нэмэгдүүлэх таатай нөхцөл бүрдээд байна. Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын таамаглаж буйгаар ирэх 2016 онд газрын тосны үнэ одоогийн түвшинд хадгалагдах төлөвтэй байгааг харгалзан онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулж, төвийн боомтуудаар импортлох автобензин тус бүрд тонн тутамд 200 мянган төгрөгөөр, дизелийн түлшинд 300 мянган төгрөгөөр татварыг нэмэгдүүлэхээр хуулийн төсөл боловсруулаад байна.

Хуульд өөрчлөлт оруулж татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээр шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшин өмнө нь байсан дундаж түвшин болох 7 хувьдаа хадгалагдах бөгөөд хилийн үнийн бууралтын зөрүүнээс улсын төсөвт 2015 оны үлдэх хугацаанд 43.5 тэрбум төгрөг, 2016 онд 200.0 орчим тэрбум төгрөгийн орлого нэмж төвлөрөх боломжтой болно.

----oOo----

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны ... дугаар  
сарын ... өдөр

Төрийн ордон

**ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Өрийн удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7 дах хэсгийн “оруулж, ” гэсний дараа “концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2015 оны ... дугаар сарын ... –ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

/Гарын үсэг/

## ТАНИЛЦУУЛГА

### *Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар*

Улсын Их Хурлын 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн чуулганаар Өрийн удирдлагын тухай хуулийг баталж, хүчин төгөлдөр мөрдүүлж байна.

Хуулийн 18.8 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдоно ...” гэж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8 дахь заалтад “Засгийн газрын өр гэж а/ өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг ... хэлнэ” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг Засгийн газрын өрд оруулан тооцохоор хуульчилсан.

Өрийн удирдлагын тухай хуулийн 40.7 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, Засгийн газрын өрд бүртгэнэ.” гэж заасан бөгөөд Өрийн удирдлагын болон Концессын хуулиудад концессын гэрээг хүчин төгөлдөр болох тухай асуудлыг тодорхойлон заагаагүй байна. Концессын гэрээ нь байгуулагдсан даруйдаа тэр бүр шууд Засгийн газрын өрийг үүсгэдэггүй, болзошгүй өр төлбөрийн шинжтэй байдаг бөгөөд ажлын гүйцэтгэл, ашиглалтаас хамааран төсвөөс төлөлт хийгдэх асуудал тавигддаг.

Засгийн газрын 2015 оны 49, 70, 87, 305, 340 дүгээр тогтоолуудаар нийт 10 төслийн хүрээнд “барих-шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээ байгуулах эрхийг Хөрөнгө оруулалтын газарт олгосон бөгөөд 2015 оны 08 дугаар сарын байдлаар 465.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 4 төслийн гэрээ хүчин төгөлдөр болоод байна.

Концессын асуудал нь Концессын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуулиудаар тус тус зохицуулагдаж байгаа бөгөөд концессын гэрээнд заасан нөхцөл хангагдсан тохиолдолд гэрээг хүчин төгөлдөр гэж үздэг ба гэрээ байгуулагдан түүнийг хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд болзошгүй өр төлбөрт бүртгэх харилцааг Төсвийн тухай хуулиар тогтоосон.

Хэдийгээр концессын гэрээ хүчин төгөлдөр болсон ч гэрээнд тусгайлан заасны дагуу гэрээг цуцлах, концесс эзэмших эрхийг бусдад шилжүүлэх, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой юм. Энэ тохиолдолд Засгийн газрын өрийн бүртгэлд энэхүү өөрчлөлтийг хэрхэн оруулах харилцаа нь эрх зүйн хувьд зохицуулалтгүй орхигдож байна.

Иймд, концессын гэрээнд заасны дагуу нийт үнийн дүнгээр Засгийн газрын өр үүсгэн бүртгэхээс илүүтэйгээр тухайн улиралд гарсан ашиглалтаар өрд тооцож, бүртгэж байх нь зүйтэй бөгөөд концесс эзэмшигчийн зүгээс тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд гаргасан санхүүжилт, гүйцэтгэлд үндэслэн тайлагнах нь Засгийн газарт өрийг бодитоор тооцон гаргах боломжийг бүрдүүлэхээр байна.

Засгийн газрын өрийн тайлан, эргэн төлөлтийг төлөвлөх асуудлыг илүү оновчтой болгох зорилгоор Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсрууллаа. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессыг гэрээ хүчин төгөлдөр болсноор өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулах, гарсан ашиглалтаар Засгийн газрын өрд бүртгэх зохицуулалттай болж, энэ асуудлаарх төрийн байгууллагуудын ажлын уялдаа, холбоо сайжрах ач холбогдолтой юм.

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны ... дугаар  
сарын ... өдөр

Төрийн ордон

**КОНЦЕССЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Концессын тухай хуулийн 6, 26 дугаар зүйлд дор дурдсан 6.2.13 дах заалт, 26 дугаар зүйлд 26.4.6 дах заалтыг тус тус нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.2.13 дах заалт:

“6.2.13. Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь холбогдох журмын дагуу концесс эзэмшигчээс концессын гэрээний ашиглалт, төсөл арга, хэмжээний гүйцэтгэлийн тайланг улирал бүр гаргуулан авч, нэгтгэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.”

2/26 дугаар зүйлийн 26.4.6 дах заалт:

“26.4.6. Концесс эзэмшигч нь концессын гэрээний дагуу гарсан ашиглалт, гүйцэтгэлийг холбогдох журмын дагуу улирал бүр концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнах үүрэгтэй.”

**2. дугаар зүйл.** Концессын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.17 дах заалтын “мэдээ” гэсний өмнө “ашиглалтын тайлан” гэж нэмсүгэй.

**3. дугаар зүйл.** Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.13 гэснийг 6.2.14 гэж, 26 дугаар зүйлийн 26.4.6 гэснийг 26.4.7 гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**2015 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “дэд сайд,” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**2015 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “, дэд сайдын аль нэг нь” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**2015 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “дэд сайд,” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**2015 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “, дэд сайд” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/ 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3. Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана:

#### **Ерөнхий чиг үүргийн**

- 1/Байгаль орчин, хөгжлийн яам;
- 2/Гадаад хэргийн яам;
- 3/Сангийн яам;
- 4/Хууль зүй, дотоод хэргийн яам;

#### **Чиглэлийн**

- 5/Батлан хамгаалах яам;
- 6/Гэгээрлийн яам
- 7/Дэд бүтцийн яам;
- 8/Хөдөө аж ахуйн яам;
- 9/Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам.

#### **2/ 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

4.Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээнд дараах асуудал хамаарна:

- улсын тогтвортой хөгжлийн бодлого;
- эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох асуудал;
- хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалт, бүртгэл;
- тагнуул, сөрөг тагнуул, терроризмаас урьдчилан сэргийлэх асуудал;
- мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны асуудал;
- цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах асуудал.

### **3/ 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Засгийн газрын гишүүн дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:

#### **1/ Монгол Улсын Шадар сайд:**

- гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал;
- хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой шуурхай асуудал;
- стандартчилал, хэмжил зүйн асуудал;
- шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудал;
- хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал;
- оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал.

#### **2/ Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга:**

- Засгийн газрын шийдвэрийн биелэлт;
- Засгийн газрын дотоод мэдээлэл;
- Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах асуудал;
- иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх асуудал;
- орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, удирдлага;
- Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах асуудал;
- хилийн боомтуудын үйл ажиллагааг уялдуулах, нэгдсэн зохицуулалтаар хангах бодлого;
- орон нутгийн (хүн амын хөгжлийн бодлоготой уялдуулан) хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн асуудал;
- төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа бүх төрлийн зөвшөөрлийн нэгтсэн бүртгэл, мэдээллийн сан;
- тодорхой салбарын мэргэжлийн хяналтын асуудал;
- төрийн албаны хүний нөөцийг давтан сургах асуудал.

#### **3/ Байгаль орчин, хөгжлийн сайд:**

- ногоон хөгжлийн бодлого;
- байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого;
- газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого;
- цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын асуудал;
- усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах асуудал;
- ургамал, ан амьтны нөөцийг хамгаалах асуудал, мэдээллийн сан;
- байгаль орчны шинжилгээ, ус, цаг уур болон байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал;
- биоаюулгүй байдлын бодлогын асуудал;
- агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал;
- аялал жуулчлалын бодлого.

#### 4/ Монгол Улсын Гадаад хэргийн сайд:

- гадаад орон, олон улсын байгууллагатай улс төрийн талаархи хамтын ажиллагаа;
- эдийн засгийн хамтын ажиллагааны нэгдсэн бодлого, зохицуулалт;
- гадаад худалдааны бодлого;
- гадаад орон, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээрийн асуудал, байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад тавих хяналт;
- гадаадад байгаа Монгол Улсын иргэд, бизнесийн эрх ашгийг хамгаалах асуудал;
- дипломат, албан зэргийн виз, консулын асуудал;
- гадаад улс, олон улсын байгууллагатай хүмүүнлэгийн чиглэлийн хамтын ажиллагаа;
- гадаад сурталчилгаа.

#### 5/ Монгол Улсын Сангийн сайд:

- улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал;
- зээл, тусламжийн нэгдсэн бодлого;
- нэгдсэн төсвийн талаарх судалгаа, төлөвлөлт;
- улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалтын хяналт;
- нягтлан бодох бүртгэлийн бодлого;
- гаалийн бодлого;
- татварын бодлого;
- даатгалын бодлого;
- төрийн өмчийн бодлого, бүртгэл хяналт;
- санхүүгийн зах зээл, төсвийн орлого, зарлага, өрийн удирдлагын асуудал;
- төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагаа;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах бодлого зохицуулалт;
- бүс нутгийн болон чөлөөт бүсийн хөгжлийн асуудал;
- концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого.

#### 6/ Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд:

- эрх зүйн шинэтгэлийн бодлого;
- хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;
- эрх зүйн туслалцаа;
- архивын талаар төрөөс баримтлах бодлого;
- шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;
- энгийн зэргийн виз, Монгол Улсад орох, гарах, оршин суух гадаадын иргэний асуудал;
- иргэний харьяалал, цагаачлалын асуудал;
- улсын хил хамгааллын асуудал;
- хэвлэл, мэдээллийн хэрэгслийн бүртгэл;
- төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;
- Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, хуульчдын олон нийтийн байгууллагатай харилцах асуудал;

- цагдаа, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал;
- төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянах асуудал;
- иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;
- статистикийн мэдээлэл;
- улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах асуудал.

#### 7/ Монгол Улсын Батлан хамгаалахын сайд:

- улсыг батлан хамгаалах болон цэргийн бодлого;
- зэвсэгт хүчнийг чадваржуулах бодлого;
- энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэл хангуулах асуудал.

#### 8/ Монгол Улсын Гэгээрлийн сайд:

- боловсролын тогтолцоог хөгжүүлэх асуудал;
- шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, мэдээлэл;
- өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал;
- соёл, урлагийг хөгжүүлэх бодлого;
- түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого;
- ном, хэвлэл, цахим бичвэрийн бодлого;
- мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тогтолцоог хөгжүүлэх асуудал.

#### 9/ Монгол Улсын Дэд бүтцийн сайд:

- барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого;
- хот төлөвлөлт болон хот байгуулалтын бодлого, архитектурын асуудал;
- газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал;
- орон сууц, нийтийн аж ахуйн бодлого;
- хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн бодлого, аж үйлдвэрийн паркийн асуудал;
- жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн асуудал;
- геологи, эрдэс баялгийн бодлого;
- геологийн эрэл, хайгуул, судалгааны асуудал;
- газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого;
- олборлох үйлдвэрийн техник, технологийн асуудал;
- ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх асуудал;
- эрчим хүчний нэгдсэн бодлого;
- эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн асуудал;
- сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлого;
- түлшний хангамж, нөөцийн бодлого, зохицуулалт;
- авто тээврийн асуудал;
- тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлого, зохицуулалт;
- төмөр зам, авто зам, иргэний нисэхийг хөгжүүлэх бодлого;
- далай ашиглах болон усан замын тээврийн асуудал.



9/ Монгол Улсын Хөдөө аж ахуйн сайд:

- хүн амын хүнсний хангамжийн бодлого;
- хүнсний аюулгүй байдлын асуудал;
- дотоод худалдаа;
- мал аж ахуй болон газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого;
- бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал;
- малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого;
- хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого;
- мал, амьтан, ургамлын хорио цээрийн асуудал;
- мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эдийн экспорт, импортын асуудал.

10/ Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд:

- хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх бодлого;
- эм, эмнэлгийн хэрэгсэл, техникийн үйлдвэрлэл, хангамжийн талаархи бодлого;
- эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар судлалын хүрээний бодлого;
- нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бодлого;
- мэргэжлийн спортын хөгжлийн асуудал;
- хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;
- нийгмийн халамжийн бодлого;
- хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын болон гэр бүлийн хөгжлийн асуудал;
- жендерийн хөгжлийн асуудал;
- нийгмийн даатгалын бодлого;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн асуудал.
- хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах бодлого;
- хөдөлмөрийн харилцаа, Засгийн газар, эзэд, Үйлдвэрчний эвлэлийн гурван талт түншлэл, хөдөлмөрийн хамтын маргааны зохицуулалтын асуудал;
- хөдөлмөрийн нөхцөл, ажиллагчдын цалин, амьдралын өртгийн талаарх асуудал;
- хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт, хөдөлмөрийн биржийн асуудал;
- Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэний асуудал;
- гадаадад ажиллах хүч гаргах асуудал.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “сайд, дэд” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18<sup>1</sup> дүгээр зүйл, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлийг 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс, 2, 3 дугаар зүйлийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

### ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.9 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын “26,” гэсний дараа “27,” гэж, мөн заалтын “харгалзан” гэсний дараа “, 27 дугаар бүлэгт заасан газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний хувьд Онцгой албан татварын тухай хуулийн 6.2-т заасан хилийн боомт тус бүрээр ялгавартай” гэж тус тус нэмсүгэй.

2. Мөн тогтоолын хавсралтын 27 дугаар бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

			Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн	0-10
27		2716.00.00	Эрдэс түлш, битумын эрдэс, эрдэс лав	5
			Цахилгаан эрчим хүч	5

3. Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**ГАРЫН ҮСЭГ**

## ТАНИЛЦУУЛГА

### *Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төсөл*

Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнийн савлагааг зохицуулж дотоодын автобензин, дизелийн түлшний үнийг тогтвортой байлгах, цаашлаад өргөн хэрэглээний барааны үнийг өсөхөөс сэргийлж автобензин, дизелийн түлшний хилийн үнээс хамааруулан онцгой албан татвар, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээг УИХ-аас баталсан хязгаарт багтаан Засгийн газар тухай бүр тогтоож байна.

УИХ-аас олгосон эрхийн дагуу автобензин, дизелийн түлшний хилийн үнэ өсөх үед Засгийн газраас шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааг зохих түвшинд хадгалан дээрх татваруудыг бууруулах, харин хилийн үнэ буурахад татваруудыг нэмэх зохицуулалтыг тухай бүр хэрэгжүүлж байсны үр дүнд дотоодын зах зээл дэх үнийн огцом өөрчлөлтийг сааруулан, харьцангуй тогтвортой түвшинд хадгалж ирсэн билээ.

Хамгийн сүүлд Засгийн газрын 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 65 дугаар тогтоолоор автобензин, дизелийн түлшинд ногдуулдаг гаалийн албан татварын хувь хэмжээг "1" хувь байсныг "5" хувь байхаар байхаар тогтоогоод байна. Ийнхүү татварын хувь хэмжээг тогтоолд заасан хамгийн дээд дүнгээр тогтоосон ч хилийн үнийн бууралтын улмаас шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшин дунджаар 10 гаруй хувиас даваад байна.

Өнгөрсөн оны сүүлийн хагас жилээс эхлэн дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ тогтмол буурч, үүнийг дагаад ОХУ-аас импортоор авдаг автобензин, дизелийн түлшний хилийн үнэ төлөвлөсөн хэмжээнээс буурч байгаа нь аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааг огцом өсгөж байгаа тул УИХ-аас баталсан татварын дээд хувь хэмжээг нэмэгдүүлэх таатай нөхцөл бүрдээд байна. Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын таамаглаж буйгаар ирэх 2016 онд газрын тосны үнэ одоогийн түвшинд хадгалагдах төлөвтэй байгааг харгалзан "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар орлогын хэмжээг нэмэгдүүлэхээр тогтоолын төслийг боловсруулаад байна.

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээр шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшин өмнө нь байсан дундаж түвшин болох 7 хувьдаа хадгалагдах бөгөөд хилийн үнийн бууралтын зөрүүнээс улсын төсөвт 2015 оны үлдэх хугацаанд 17.8 тэрбум төгрөг, 2016 онд 60.0 тэрбум төгрөгийн орлого нэмж төвлөрөх боломжтой болно.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

**2015 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн  
ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 75 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ГАРЫН ҮСЭГ**

**Монгол Улсын Их Хурлын 2015 оны ...  
дугаар тогтоолын хавсралт**

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО,  
БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ**

<b>Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал</b>	<b>Засгийн газрын тохируулагч агентлаг</b>	<b>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг</b>
Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд	1.Тагнуулын ерөнхий газар	1.Хөрөнгө оруулалтын газар
Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	2.Онцгой байдлын ерөнхий газар 3.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 4.Стандартчилал, хэмжил зүйн газар	2.Оюуны өмчийн газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд	5.Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	
Байгаль орчин, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		3.Цаг уур, орчны шинжилгээний газар
Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		4.Үндэсний орлогын газар
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	6.Зэвсэгт хүчний жанжин штаб	
Гэгээрлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Дэд бүтцийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		5.Ашигт малтмал, газрын тосны газар 6.Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар

		7.Иргэний нисэхийн ерөнхий газар
Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	7.Цагдаагийн ерөнхий газар 8.Хил хамгаалах ерөнхий газар	8. Бүртгэл, статистикийн ерөнхий газар 9.Архивын ерөнхий газар 10.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 11.Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар 12.Тахарын ерөнхий газар
Хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		13.Мал эмнэлэг, үржлийн газар
Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		14.Нийгмийн даатгалын ерөнхий газар 15.Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар 16.Хүүхдийн төлөө үндэсний газар

---oOo---

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2015 ОНЫ  
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ, ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015 ОНЫ  
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**Улаанбаатар хот**

# 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## 1.1. Макро эдийн засгийн 2015 оны эхний 8 сарын гүйцэтгэл болон 2015 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл

### 1.1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн

2015 оны эхний хагас жилд 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 7,047.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар өссөн бол оны үнээр илэрхийлсэн ДНБ 10,690.0 тэрбум төгрөгт хүрч 7.8 хувиар өссөн байна. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн салбар 9.4 хувь, уул уурхайн салбар 16.5 хувь, боловсруулах үйлдвэр 5.2 хувиар тус тус өссөн нь эерэг нөлөө үзүүлсэн бол бөөний болон жижиглэнгийн худалдаа үйлчилгээний салбар 7.6 хувь, тээврийн салбар 4 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 14.5 хувиар тус тус буурсан нь сөргөөр нөлөөлсөн байна. Дээрх салбаруудын бууралт нь эдийн засгийн идэвхжил саарч, бараа бүтээгдэхүүний эргэлт удааширч, импорт хумигдсантай холбоотой байна.

**Хөдөө аж ахуйн салбар:** Энэ оны эхний хагас жилд 66.5 сая толгой мал тоологдсоноос адуу 3,5 сая, үхэр 4,3 сая, тэмээ 394.2 мянга, хонь 30,5 сая, ямаа 27,9 сая байна. 2015 оны эхний хагас жилд төллөх насны 22.2 сая хээлтэгч малаас 19.3 сая толгой мал төллөж, гарсан төлийн 96.8 хувь болох 18.7 сая толгой төл бойжиж байна. Мал аж ахуйн салбар өсөлт өндөртэй байгаагийн нөлөөгөөр 2015 оны эцэст нийт хөдөө аж ахуйн салбар 6.8 хувиар өсөх төлөвтэй байна.


**Уул уурхайн салбар:** 2015 оны эхний хагас жилд уул уурхайн салбар 16.5 хувиар өсөв. Үүнд газрын тосны олборлолт 15 хувиар, зэсийн баяжмалын үйлдвэрлэл 23.4 хувиар, алтны олборлолт 22.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн бол төмрийн хүдрийн үйлдвэрлэл 47 хувиар, нүүрсний олборлолт 2.4 хувиар тус тус буурсан нь уул уурхайн салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна.

**Үйлчилгээний салбар:** 2015 оны эхний хагас жилд жижиглэн худалдааны борлуулалт 4.7 хувиар өсөж, 2565.5 тэрбум төгрөгт хүрсэн боловч бөөний худалдааны борлуулалт 5.1 хувиар буурсан тул нийт худалдааны салбарын борлуулалт 0.5 хувиар буураад байна. 2015 оны эхний хагас жилд төмөр замаар тээсэн ачаа 7.9 хувиар, зорчигчдын тоо 10.8 хувиар, агаарын тээврээр тээсэн ачаа 19.5 хувиар, зорчигчдын тоо 12.7 хувиар тус тус буурсан тул шуудан, харилцаа, холбооны үйлчилгээний салбарын орлого 2.8 хувиар буурсан байна.

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2015 оны эцэст ДНБ-ий өсөлт 3.1 хувь байх төлөвтэй байна. ДНБ-ий өсөлтөд хөдөө аж ахуйн салбар 6.8 хувиар, уул уурхайн салбар 11.4 хувиар тус тус өсөхөөр байгаа нь голлон нөлөөлж байна. Гэвч эдийн засгийн идэвхжил саарсан, бараа бүтээгдэхүүний эргэлт буурч, импорт агшсантай холбоотойгоор барилга, үйлчилгээний салбарууд болон шууд бус татварын өсөлт саарахаар байна.



**График 1. Эдийн засгийн өсөлт 2010-2015 он**



\*-хүлээгдэж буй гүйцэтгэл

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Сангийн яам


### 1.1.2. Ажилгүйдлийн түвшин

Ажиллах хүчний түүвэр судалгаанаас үзвэл 2015 оны 2 дугаар улирлын байдлаар эдийн засгийн идэвхтэй хүн ам өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өсөж, 1242.6 мянгад, ажиллагчдын тоо 3.9 хувиар өсөж, 1145.3 мянгад хүрсэн бол ажилгүй иргэдийн тоо 4.0 хувиар буурсан байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 2015 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурав. Ажиллагчдын тоо өсөхөд үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт ажиллагчдын тооны өсөлт нөлөөлсөн байна. Харин хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын тоо буурсан байна.

### 1.1.3. Инфляц

Инфляцын түвшин 2015 оны эхний 8 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.6 хувь, оны эхнээс 3.4 хувьтай гарлаа. Харин 2014 оны 12 дугаар сараас өнөөг хүртэл махны бүлгийн жилийн инфляц харьцангуй бага, дийлэнх саруудад үнийн бууралттай байсан нь инфляцад эерэг нөлөөлсөн байна.

**График 2. Инфляцын түвшин, эхний 8 сарын гүйцэтгэл**




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Сангийн яам

#### 1.1.4. Мөнгөний нийлүүлэлт

2015 оны 8 дугаар сарын байдлаар мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувиар буурч, 9.96 их наяд төгрөгт хүрлээ. Энэ оны 8 дугаар сарын байдлаар нийт мөнгөний нийлүүлэлтийн 50.9 хувийг төгрөгийн хадгаламж, 21.5 хувийг гадаад валютын хадгаламж, 10.7 хувийг гадаад валютын харилцах, 12.4 хувийг төгрөгийн харилцах, үлдсэн 4.5 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө эзэлж байна.

График 3. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн өрийн үлдэгдлийн өөрчлөлт /хувь/



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо


2015 оны 5 дугаар сард Худалдаа Хөгжлийн банкнаас олон улсын зах зээл дээр 500.0 сая ам.долларын, 6 дугаар сард Монгол Улсын Засгийн газраас 161.0 сая ам.доллартай тэнцэх хэмжээний юаний бонд гаргасан нь гадаад активын хэмжээ өсөхөд хүргэсэн ч Монголбанкнаас Төв банкны үнэт цаасны хэмжээг 1.1 их наяд хүртэл төгрөгөөр нэмэгдүүлсэн тул нийт мөнгөний нийлүүлэлт нэмэгдээгүй байна.

#### 1.1.5. Төлбөрийн тэнцэл

2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,017.5 сая ам.доллараар буурч, төлбөрийн тэнцэл 82.3 сая ам.долларын ашигтай гарлаа. Данснуудаар авч үзвэл, урсгал данс 410.2 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.2 дахин буурсан бол хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 1.5 дахин өсөж, 661.0 сая ам.долларт хүрэв.

Хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг өсөхөд, тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн газар 161.0 сая ам.доллартай тэнцэх юаний бондыг 7.5 хувийн хүүтэйгээр 3 жилийн хугацаатай, Худалдаа Хөгжлийн банк 500.0 сая ам.долларын бондыг олон улсын зах зээл дээр 9.375 хүүтэй, 5 жилийн хугацаатайгаар амжилттай арилжаалсан нь голлон нөлөөлжээ.

**График 4. Төлбөрийн тэнцлийн жил бүрийн эхний хагас жилийн гүйцэтгэл /сая ам.доллар/**



\*Хүлээгдэж буй гүйцэтгэл


Эх үүсвэр: Монголбанк

### 1.1.6. Гадаад худалдаа

2015 оны эхний 8 сард гадаад худалдааны нийт бараа эргэлт 5,798.4 сая ам.доллар, үүнээс экспорт 3,251.6 сая ам.доллар, импорт 2,546.8 сая ам.долларт хүрчээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бараа эргэлтийн хэмжээ 1,353.0 сая ам.доллар буюу 18.9 хувь, экспортын хэмжээ 324.1 сая ам.доллар буюу 9.0 хувь, импортын хэмжээ 1,028.9 сая ам.доллар буюу 28.8 хувиар тус тус буурчээ.

Монгол Улс 2015 оны эхний 8 сард дэлхийн 140 оронтой худалдаа хийснээс нийт бараа эргэлтийн 63.8 хувь буюу 3,697.1 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12.7 хувь буюу 733.6 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийж, 23.5 хувь буюу 1,367.7 сая ам.долларын худалдааг бусад улс орнуудтай хийжээ.

**График 5. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, сая ам.доллар**



Эх үүсвэр: YCX

## **2. ТӨСӨВТ ТОДОТГОЛ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ХАМРАХ ХҮРЭЭ**

### **2.1. ТӨСӨВТ ТОДОТГОЛ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ**

Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнийн уналтаас шалтгаалан Монгол Улсын 2015 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс **900** гаруй тэрбум төгрөгөөр буурахаар байна. Иймд 2015 оны төсвийн орлогыг бодитойгоор тооцож батлагдсан хэмжээг бууруулах, үүнтэй уялдуулан урсгал болон хөрөнгийн зардлыг дахин тооцож бууруулах замаар төсвийг тэнцвэржүүлэх зорилгоор 2015 оны төсвийн тодотголыг боловсрууллаа.

Төсвийн тухай хуулийн 6.2.3-т “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлнэ” гэж заасныг үндэслэн Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

### **2.2. ТӨСӨВТ ТОДОТГОЛ ХИЙХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ**

Төсвийн орлогын 2015 оны батлагдсан төсөвт тодотгол хийхдээ дараах зарчим баримталлаа. Үүнд:

1. Монгол Улсын 2015 оны эдийн засгийн төлөв байдал, төсвийн орлогын гүйцэтгэл зэрэгт үндэслэн 2015 оны төсвийн орлогыг бууруулан дахин төлөвлөх;
2. Монгол Улсын 2015 оны төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж болон макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөлд тулгуурлан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцож боловсруулах;
3. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хуулийн өөрчлөлтийг боловсруулж, орлогын өөрчлөлтийг тусгах;

Төсвийн зарлагын төлөвлөгөөнд тодотгол хийхдээ дараах зарчим баримталлаа. Үүнд:

1. Төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл буурч байгаатай уялдуулан Засгийн газрын шийдвэрээр санхүүжилтийг нь хойшлуулсан зардлыг хэмнэж, бууруулах;
2. Оны эхний 8 сарын төсвийн гүйцэтгэлээр зарцуулагдаагүй зарим урсгал зардлыг бууруулах, зайлшгүй шаардлагатай бол 2016 оны төсөвт тусган санхүүжүүлэх;
3. Төрийн улс төрийн болон өндөр албан тушаалтны цалинг 30 хувь бууруулах, бусад төрийн албан хаагчдын цалинг бууруулахгүй байх;
4. Шинээр батлагдсан хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний хамрах хүрээний өргөжилтөөс үүдэлтэй урсгал зардлыг төсөвт нэмж тусгах.

## 2.3. УЛСЫН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТУХАЙ

### 2.3.1. ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6,632.6 тэрбум төгрөг буюу өмнөх оны гүйцэтгэлээс 5.7 орчим хувиар өснө гэж тооцсон. Гэвч энэ оны эхний 8 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 3,576.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 221.2 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн хэмжээнээс 660.7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан.

Төсвийн орлого ийнхүү буурахад нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн албан татвар, өмч хувьчлал, газрын тос, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын бууралт гол нөлөө үзүүлсэн. Төсвийн орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн орлогын нэр төрлийг хүснэгтлэн үзүүлбэл:

**Хүснэгт 1. Төсвийн орлогын голлох бууралтууд /тэрбум төгрөг/**

Үзүүлэлт	ӨО-ны		жилийн		8 сарын байдлаар		Зөрүү	
	мөн үеийн	Төлөв.	Төлөв.	Гүйцэт.	ХУВЬ	ДҮН		
	.1.	.2.	.3.	.4.	.4 - 3.	.4 - 2.	.4 - 3.	
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,842.0	6,662.5	4,258.2	3,579.1	84.1%	53.7%	-679.2	
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	44.0	29.9	20.8	2.3	11.1%	7.7%	-18.5	
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,798.0	6,632.6	4,237.4	3,576.8	84.4%	53.9%	-660.7	
Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого	883.8	1,254.00	864.9	667.7	77.2%	53.2%	-197.2	
Өмч хувьчлалын орлого	9.4	181.4	163.6	8.4	5.1%	4.6%	-155.2	
Газрын тосны орлого	158.0	284.9	186.7	118.1	63.2%	41.5%	-68.6	
Хүүгийн орлого	0.0	152.7	69.3	72.6	104.8%	47.5%	3.3	
Онцгой албан татвар	299.7	621.2	411.2	363.5	88.4%	58.5%	-47.7	
Импортын гаалийн албан татвар	243.6	376.3	259.1	213.5	82.4%	56.7%	-45.6	
ААН-ын орлогын албан татвар	348.1	651.8	394.0	353.0	89.6%	54.2%	-41.0	
Хандив тусламж /гадаад/	0.0	62.6	42.5	31.3	73.6%	50.0%	-11.2	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	245.6	426.9	317.5	287.8	90.7%	67.4%	-29.7	
Хувь хүний орлогын албан татвар	313.0	540.7	348.5	319.5	91.7%	59.1%	-28.9	
Хувьцааны ногдол ашиг	28.5	97.5	27.8	2.4	8.6%	2.5%	-25.4	
Газрын төлбөр	36.7	50.4	29.4	36.4	123.7%	72.3%	7.0	

Энэ 2015 оны эхний 8 сарын гүйцэтгэлээс харахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого оны эцэст 900 гаруй тэрбум төгрөгөөр тасрахаар байна. Иймээс төсвийн орлогын тасалдлыг багасгах зорилгоор дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн бууралттай уялдуулан шатахууны гаалийн болон онцгой албан татварыг нэмэгдүүлэх, татварын хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар 400.0 орчим тэрбум төгрөгийн орлогыг төсөвт нэмж төвлөрүүлэхээр тооцож, холбогдох хуулийн төслүүдийг боловсрууллаа.

Өнгөрсөн оны сүүлийн хагас жилээс эхлэн дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ тогтмол буурсан. Үүнээс үүдэн ОХУ-аас импортоор худалдан авдаг авто бензин, дизелийн түлшний хилийн үнэ төлөвлөсөн хэмжээнээс буурч, газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаа дээшилж байгаа тул газрын тосны бүтээгдэхүүнд ногдуулдаг гаалийн болон онцгой албан татварын хувь, хэмжээний дээд хязгаарыг нэмэгдүүлэх боломж бүрдээд байна.

Ийнхүү зөвхөн төвийн боомтуудаар импортлох авто бензин, дизелийн түлшинд ногдох онцгой албан татварын дээд хязгаарыг авто бензиний хувьд тонн тутамд 200.0 мянган төгрөгөөр, дизелийн түлшинд тонн тутамд 300.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхээр хуулийн төсөл боловсруулаад байна. Үүнтэй зэрэгцэн импортын гаалийн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, төвийн боомтуудаар импортолож буй авто бензин, дизель түлшинд ногдох гаалийн албан татварын дээд хувь хэмжээг 0-10 хувь байхаар тогтоолын төсөл боловсруулаад байна. Авто бензин, дизель түлшинд ногдох гаалийн болон онцгой албан татварын хувь, хэмжээний дээд хязгаарыг нэмэгдүүлж, газрын тосны дэлхийн зах зээл дээрх үнийн бууралттай уялдуулан гаалийн болон онцгой албан татварын хэмжээг тогтоосноор энэ онд 61.3 орчим тэрбум төгрөгийн орлого төсөвт нэмж төвлөрүүлэх боломжтой гэж үзлээ.

Төсвийн орлого нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 6,128.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 504.6 тэрбум төгрөгөөр буурахаар тодотголд тусгалаа. Тус бууралтыг орлогын ангиллаар харуулбал:

### Хүснэгт 2. Төсвийн тодотголд орох өөрчлөлтүүд /тэрбум төг/

Төсвийн орлого	2014-08	2014	2015-8 сар		2015		Зөрүү	
	Гүйц	Гүйц	Төл	Гүйц	Төл	ХБГ	8 сар	Жил
	.1.	.2.	.3.	.4.	.5.	.6.	.4 - 3.	.6 - 5.
Тэнцвэржүүлсэн нийт орлого	3,798.0	6,276.6	4,237.4	3,576.8	6,632.6	6,128.0	-660.7	-504.6
Орлогын ангиллаар								
Татварын орлого	3,233.6	5,157.0	3,448.2	3,068.4	5,400.1	5,145.7	-379.8	-254.4
Татварын бус орлого	564.4	1,119.6	789.2	508.4	1,232.5	982.3	-280.8	-250.2

### Хүснэгт 3. Төсвийн тодотголын өөрчлөлтүүдэд нөлөөлж буй голлох хүчин зүйлс

Орлогод нөлөөлсөн үзүүлэлтүүд	Хэмжигч нэгж	2014-08	2015-08	2014	2015		Зөрүү	
		Гүйц	Гүйц	Гүйц	Төл	ХБГ	8 сар	Жил
		.1.	.2.	.3.	.4.	.5.	.2 - 1.	.5 - 4.
1. Импорт	сая \$	3,584.0	2,554.0	5,257.0	5,734.0	3,813.5	-1,030	-1,921
2. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	сая \$	2,921.6	2,541.0	4,777.7	3,830.3	3,792.4	-380.6	-37.9
Үнэ								
Зэсийн үнэ	\$/тонн	6,947.1	5,768.5	6,863.4	6,354.7	5,560.0	-1178.6	-794.7
Нүүрсний үнэ	\$/тонн	49.1;	37.7;	48.4;71.9	30; 60	35.7;	-18.1	-16.1

		74.6	56.5			56.1		
Газрын тос	\$/бар	99.0	56.2	92.2	90.0	50.0	-42.8	-40.0
Тоо хэмжээ								
Зэсийн баяжмал	мян тонн	844.3	924.2	1378.1	1250.0	1295.3	79.9	45.3
Нүүрс	сая тонн	11.9	9.6	19.5	15.0	13.7	-2.3	-1.3
Газрын тос	сая бар	4441.1	5193.1	6885.1	7597.6	8026.7	752.0	429.1

Төсвийн орлогын бууралтад импорт, газрын тос, зэсийн үнийн бууралт голлох нөлөөг үзүүлжээ.


### Нэг. Импортын бууралтаас шалтгаалан

**Импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар:** Энэ 2015 онд импортын хэмжээг эдийн засгийн өсөлттэй уялдуулан 5.7 тэрбум ам.доллар байхаар тооцсон. Гэтэл энэ оны эхний 8 сарын гүйцэтгэлээр импортын хэмжээ 2.5 тэрбум ам.доллар байгаа нь өмнөх оны мөн үеэс 30 орчим хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Импортын бууралтын дийлэнх хэсэг болох 52 орчим хувь буюу 546.0 сая ам.доллар нь хөрөнгө оруулалтын шинж чанартай байх бөгөөд энэ нь уул уурхайн бүтээн байгуулалтын ажил удааширсантай холбоотой байна. Түүнчлэн дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ буурч, түүнийг дагаад нефтийн бүтээгдэхүүний хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 32 хувиар буурсантай холбогдуулан нефтийн бүтээгдэхүүний импортын үнэлгээ 36 хувиар буюу 270.0 сая ам.доллараар буурсан.

Импортын хэмжээ ийнхүү буурч байгаатай холбогдуулан энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт импортын хэмжээ 3.8 тэрбум ам.долларт хүрч, гаалийн байгууллагаас улсын төсөвт төвлөрүүлдэг орлого төлөвлөсөн хэмжээнээс 247.9 тэрбум төгрөгөөр буурахаар байна.


**График 6. Импортын хэмжээ, сая ам.доллар /2010-2015/**



### Хоёр. Газрын тосны үнийн бууралтаас шалтгаалан

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад газрын тосны хайгуул судалгааны ажил эрчимжиж, олборлолтын хэмжээ жилээс жилд нэмэгдсээр байгаа бөгөөд олборлолт жилд дунджаар 34.0 хувиар өсөж байна. Үүнтэй уялдуулан 2015 онд газрын тосны экспортын хэмжээг 7.6 сая баррелиас доошгүй байхаар, 1 баррель газрын тосны үнийг дунджаар 80.0 ам.доллар байхаар тооцож, газрын тосны орлогоор 284.9 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тусгасан.

**График 7. Газрын тосны үнэ, ам.доллар/баррель**



Харин өнгөрсөн оны 8 дугаар сараас эхлэн дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ тасралтгүй буурсаар 2015 оны 7 дугаар сард нэг баррель түүхий тосны үнэ 50-60 ам.долларт хэлбэлзэж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 46 хувиар буурсан байна. Газрын тосны үнийн төсөөллийг хийдэг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын таамаглаж буйгаар энэхүү үнийн бууралт үргэлжлэх төлөвтэй байна. Иймд 2015 онд газрын тосны орлого төлөвлөсөн хэмжээнээс 124.0 гаруй тэрбум төгрөгөөр буурч 160.9 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгав.

### Гурав. Дотоод эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалсан

**Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар:** Эдийн засгийн өсөлтийн хурд саарсан, гадаад валютын ханш өссөн, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан зэргээс шалтгаалан аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшин сүүлийн жилүүдэд буурсаар байна. Нөгөө талаас, манай улсын ДНБ-ий бодит өсөлт өнгөрсөн оны эхний хагас жилийн байдлаар 5.3 хувь байсан бол энэ оны эхний хагаст дөнгөж 3 хувьтай гарч өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр буурчээ.

**Хүснэгт 4. Бүтээгдэхүүний цэвэр татвар**

	1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН					Зөрүү
	2012 гүйц	2013 гүйц	2014 гүйц	2014.II	2015.II	
Нэрлэсэн ДНБ /оны үнээр/	16,688.4	19,174.2	21,975.5	9,918.7	10,690.0	771.3
Хөдөө аж ахуй	1,878.8	2,572.0	2,972.8	1,348.1	1,734.6	386.5



Аж үйлдвэр, барилга	5,135.3	5,849.5	7,045.1	2,957.1	3,084.8	127.7
Үйлчилгээ	7,819.9	8,574.2	9,882.3	4,562.5	4,917.7	355.2
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1,854.4	2,178.6	2,075.3	1,051.0	953.0	(98.0)
Бодит ДНБ-ий өсөлт	12.3%	11.6%	7.8%	5.3%	3.0%	-2.3

Хөдөө аж ахуй, үйлчилгээний салбар, аж ахуйн үйлдвэрлэлийн салбар тэр дундаа төсвийн орлогын гүйцэтгэлд жинтэй хувь нэмэр оруулдаг уул уурхайн олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оноос буурсан нь ДНБ-ий өсөлт саарахад гол нөлөөг үзүүлжээ.

Дээрх нөхцөл байдлаас хамаарч аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого нийт 133.0 орчим тэрбум төгрөгөөр буурах төлөвтэй байна.

### **Өмч хувьчлалын орлого:**

Энэ онд “МИАТ” ХК-ийн 49 хувь, “Хөтөлийн цемент шохой” ХК, “Хөрөнгийн бирж” ХК зэрэг төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг хувьчлах замаар төсөвт 181.4 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр тооцсон.

Гэвч УИХ-ын 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хувьчлагдах аж ахуйн нэгжийн жагсаалтыг батлахдаа энэ онд хувьчлагдахаар тооцсон зарим аж ахуйн нэгжийг хассан нь өмч хувьчлалын орлого буурахад нөлөөлжээ.

Иймд 2015 онд төсөвт төвлөрүүлэх өмч хувьчлалын орлогыг 114.2 тэрбум төгрөгөөр бууруулж, 67.3 тэрбум төгрөг байхаар төсөвт тусгав.

### **Дөрөв. Эрдэс бүтээгдэхүүний үнийн бууралт**

Энэ 2015 оны төсвийн төсөлд дэлхийн зах зээл дээрх цэвэр зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 6,354.7 ам.доллар байхаар тооцсон. Гэвч энэ оны эхний 8 сарын байдлаар зэсийн 5,768.5 ам.долларт хэлбэлзэж, төлөвлөснөөс 586.2 ам.доллараар буурчээ. Түүнчлэн нүүрсний экспортын хэмжээ энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 13.7 сая тонн хүрч, төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байхаар байна. Эдгээр хүчин зүйлээс шалтгаалж төсөвт төвлөрүүлэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого буурах боловч тус татвараар өмнөх жилүүдэд хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах замаар энэхүү бууралтыг нөхөх боломжтой гэж үзлээ.

Гэхдээ зарим төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт төлөвлөсөн хэмжээнээс буурч болзошгүй байгаа тул гаалийн тэмдэгтийн хураамжийн орлогыг 6.7 тэрбум төгрөгөөр бууруулж 28.3 тэрбум, агаарын бохирдлын төлбөрийн орлогыг 2.1 тэрбум төгрөгөөр бууруулж 14.9 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.

Төсвийн тодотголоор нэгдсэн төсвийн орлогод орж буй өөрчлөлтийг өсөлт, бууралтаар нь хүснэгтлэн харуулбал дараах байдалтай байна.

### Хүснэгт 5. Төсвийн тодотголоор орж буй өөрчлөлт /тэрбум төгрөг/

<b>Төлөвлөснөөс буурах орлого:</b>	<b>-901.3</b>
Импортын бууралтаас хамаарч	-286.8
Эрдэс бүтээгдэхүүний үнэ, экспортын хэмжээнээс хамаарч	-208.9
Дотоод эдийн засгийн байдлаас хамаарч	-291.4
Өмч хувьчлалын орлого	-114.2
<b>Нэмэгдэх орлого:</b>	<b>396.7</b>
Татварын өр төлбөр барагдуулах	325.4
Шатахууны гаалийн болон онцгой албан татварыг нэмэгдүүлэх	61.3
Навигацийн орлого	10.0
<b>НИЙТ ӨӨРЧЛӨЛТ</b>	<b>-504.6</b>

Хүснэгтээс харахад төсвийн орлогын бууралтад эдийн засгийн хүндрэл, импортын бууралт, эрдэс бүтээгдэхүүний экспортын хэмжээ, үнийн бууралт голлох нөлөөг үзүүлж байна. Шатахууны гаалийн болон онцгой албан татварыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн зохицуулалтыг хийх, татварын өр барагдуулах арга хэмжээ авснаар төсвийн орлогын дутагдлыг тодорхой хэмжээнд бууруулж, орлогын цэвэр бууралт 504.6 орчим тэрбум төгрөг байхаар төсөлд тусгалаа.

### 2.3.2. ТӨСВИЙН ЗАРЛАГА

УИХ-аас 2015 оны 1 дүгээр сард Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 7,837.4 тэрбум төгрөгөөр баталсан.

### Хүснэгт 6. Төсвийн зарлага /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2015			ЗӨРҮҮ . 12-11 .
	Төл . 10 .	Тод1 . 11 .	Тод2 . 12 .	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,599.2</b>	<b>7,837.4</b>	<b>7,307.2</b>	<b>-530.3</b>
<b>А. УРСГАЛ ЗАРЛАГА</b>	<b>6,033.2</b>	<b>5,822.7</b>	<b>5,778.8</b>	<b>-43.9</b>
<b>1. Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>3,043.6</b>	<b>2,899.8</b>	<b>2,780.1</b>	<b>-119.4</b>
1.1. Цалин, хөлс	1,962.9	1,805.7	1,723.9	-81.4
1.2. Бараа, үйлчилгээний бусад зардал	1,080.7	1,094.1	1,056.2	-37.9
<b>2. Зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>696.9</b>	<b>696.9</b>	<b>731.1</b>	<b>34.7</b>
<b>3. Татаас ба урсгал шилжүүлэг</b>	<b>2,292.7</b>	<b>2,226.0</b>	<b>2,267.7</b>	<b>40.8</b>
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,565.1</b>	<b>2,015.0</b>	<b>1,578.6</b>	<b>-436.4</b>
1. Барилга байгууламж	813.9	536.6	459.5	-77.0
2. Их засвар	19.8	31.3	31.5	0.2
3. Тоног төхөөрөмж	113.8	105.8	100.9	-4.9
4. Бусад хөрөнгө	589.7	518.8	514.1	-4.7
5. Стратегийн нөөц хөрөнгө	27.8	27.8	27.8	0.0
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт		794.6	444.6	-350.0
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>0.8</b>	<b>-0.35</b>	<b>-50.3</b>	<b>-49.9</b>

Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнийн уналт үргэлжилж байгаагаас шалтгаалан Монгол Улсын 2015 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 900 гаруй тэрбум төгрөгөөр тасрахаар байгаа тул урсгал болон хөрөнгийн зардлын хэмжээг бууруулж, төсвийг тэнцвэржүүлэх шаардлагын үүднээс 2015 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа.

Уг тодотголоор нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 530.3 тэрбум төгрөгөөр буурснаас урсгал зардал 43.9 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 436.4 тэрбум төгрөгөөр тус тус буурахаар байна.

### 2.3.2.1. Төсвийн урсгал зарлага

#### Нэг. Нэгдсэн төсвийн урсгал зардлын 2015 оны эхний 8 сарын гүйцэтгэл

Улсын Их Хурлаас 2015 оны 1 дүгээр сард хийсэн тодотголоор нэгдсэн төсвийн 2015 оны урсгал зардлыг 5,822.7 тэрбум төгрөг байхаар баталсан. Нэгдсэн төсвийн урсгал зардал 2015 оны эхний 8 сард өссөн дүнгээр 3,552.9 тэрбум төгрөгт хүрч 90 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

#### Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн урсгал зардлын 2015 оны эхний 8 сарын гүйцэтгэл

	ӨО-ы мөн үе	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		ӨО-ы мөн үетэй харьцуулсан зөрүү	
			тэрб.төг	хувиар	тэрб.төг	хувиар
<b>Урсгал зардал</b>	<b>3,238.9</b>	<b>3,941.6</b>	<b>3,552.3</b>	<b>90%</b>	<b>313.5</b>	<b>10%</b>
Цалин хөлс ба НДШ	1,078.8	1,257.4	1,204.1	96%	125.3	12%
Бараа үйлчилгээний бусад зардал	512.8	760.4	532.4	70%	19.6	4%
Хүүгийн зардал	244.7	400.6	312.3	78%	67.6	28%
Татаас	115.3	92.9	99.6	107%	(15.7)	-14%
Урсгал шилжүүлэг	1,287.2	1,430.5	1,403.8	98%	116.6	9%

Гэвч өмнөх оны мөн үетэй харьцуулбал урсгал зардал нийт 313.8 тэрбум төгрөгөөр буюу 10 хувиар өссөн гүйцэтгэлтэй гарахад өмнөх оны дундуур цалин, тэтгэврийг үе шаттай нэмэгдүүлсэн, эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэн, зээлийн хүүгийн төлбөр нэмэгдсэн, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал өссөн зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс бага гүйцэтгэлтэй байгаа тул төсвийг тэнцвэржүүлэх, өр авлага үүсгэхгүй байх, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй уялдуулан зарлага, санхүүжилтийг хийх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг хангаж, бусад үйл ажиллагааны урсгал зардлыг хэмнэх, бууруулах зарчмыг баримтлан ажилласан. Үүний хүрээнд Засгийн газрын 2015 оны 230 тогтоолоор зарлага, санхүүжилтийг тодорхой хувиар бууруулах, ач холбогдлоор нь эрэмбэлэн санхүүжүүлэх чиглэлийг бүх шатны төсвийн захирагч нарт өгч, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаж байна.


## Хоёр. Нэгдсэн төсвийн урсгал зардлын тодотголын санал

Төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлийг харгалзан үзэж төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх, зардал бууруулах талаар УИХ, Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу урсгал зардлын өсөлтийг бууруулах, үр ашгийг сайжруулах чиглэл баримталж Монгол Улсын 2015 оны төсөвт дахин тодотгол хийж урсгал зардлын хэмжээг батлагдсан түвшнээс **43.9** тэрбум төгрөгөөр бууруулж, **5.778,8** тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Ингэснээр нэгдсэн төсвийн 2015 оны урсгал зардал анх батлагдсан түвшнээс 254.5 тэрбум төгрөг буюу 4.3 хувиар буурсан бол, 2014 оны төсвийн гүйцэтгэлээс 9.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Урсгал зардал өмнөх оны гүйцэтгэлийн түвшнээс өссөн гол шалтгаан нь нэгдүгээрт зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 230.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, хоёрдугаарт Засгийн газраас 2014 онд цалин, тэтгэврийг үе шаттай нэмэгдүүлсний үр дүнд 2015 онд цалин, хөлстэй холбоотой зардал 115.2 тэрбум төгрөгөөр өссөн нь шалтгаалсан байна.

**График 8. Төсвийн урсгал зарлагын хэмжээ, өсөлтийн хувь (2009-2015 оноор)**



Төсвийн орлогын өсөлттэй уялдан 2010-2012 онуудад төсвийн урсгал зардал дунджаар 35-38 хувийн өсөлттэй байсан бол сүүлийн 2-3 жилд төсвийн гүйцэтгэлээр урсгал зардлын өсөлт буурч 9.4 хувьтай гарсан байна. Мөн урсгал зардлын ДНБ-д эзлэх хувь 24-25 хувьтай буюу хэлбэлзэл харьцангуй бага байна.

**Хүснэгт 8. Урсгал зардлын хэмжээ, өсөлт, эдийн засгийн ангиллаар**

	2012	2013	2014	2015	2015	2015	Зөрүү	
	Гүйц	Гүйц	Гүйц	Төл	Тод 1	Тод 2	Тод2-Төл	Тод2-Тод1
УРСГАЛ ЗАРЛАГА	4,428.10	4,552.60	5,293.30	6,033.20	5,822.70	5,778.70	-254.50	-43.9
өсөлтийн хувь	36.8%	2.8%	16.3%	12.8%	-3.5%	-4.3%	-4.3%	-0.76%

1. Бараа, үйлчилгээний зардал	2,052.40	2,391.20	2,652.50	3,043.60	2,899.40	2,780.17	-263.43	-119.2
<i>өсөлтийн хувь</i>	<i>21.8%</i>	<i>16.5%</i>	<i>10.9%</i>	<i>15.2%</i>	<i>-4.7%</i>	<i>-8.8%</i>	<i>-86.0%</i>	<i>-4.11%</i>
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	125.9	270.4	500.3	696.9	696.9	<b>731.1</b>	34.2	34.7
<i>өсөлтийн хувь</i>	<i>237.40%</i>	<i>114.80%</i>	<i>85.0%</i>	<i>36.90%</i>	<i>0.00%</i>	<i>4.91%</i>	<b><i>4.9%</i></b>	<i>4.91%</i>
3. Татаас ба урсгал шилжүүлэг	2,249.80	1,891.00	2,140.50	2,292.70	2,226.80	2,267.40	-25.3	40.6
<i>өсөлтийн хувь</i>	<i>35.1%</i>	<i>-16.0%</i>	<i>13.2%</i>	<i>4.4%</i>	<i>-2.9%</i>	<i>-1.1%</i>	<i>-61.0%</i>	<i>1.82%</i>

Төсвийн тодотголоор урсгал зардлыг **-171,3** тэрбум төгрөгөөр бууруулахын зэрэгцээ зайлшгүй нэмэгдүүлэх зардлуудыг нэмж тусган тооцсоны үр дүнд нийт зардал **43.9** тэрбум төгрөгөөр буурахаар төсөвлөв.

Төсвийн орлогын гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулан бүх шатны төсөвт байгууллагын цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, түүнчлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, улс орны аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг сахих, гамшиг, аюул ослоос урьдчилан сэргийлэх, өвөлжилтийн бэлтгэл хангах, намрын ургац хураалттай холбоотойгоор хөдөө аж ахуй зэрэг онцлог салбаруудын урсгал төсвийг бүрэн санхүүжүүлж, харин бусад бүх шатны төсөвт байгууллагын оны сүүлийн хагас жилд төлөвлөсөн бараа ажил, үйлчилгээний зарим зардал, зарим хөтөлбөр, арга хэмжээний зардлыг тодорхой хувиар бууруулахаар Засгийн газрын 230 дугаар тогтоолоор шийдвэрлэсний дагуу төсвийн тодотголд урсгал зардлыг бууруулав.

Төрийн улс төрийн болон өндөр албан тушаалтны цалинг сүүлийн 3 сард 30 хувь бууруулах, бусад албан хаагчдын цалинг бууруулахгүй байх зарчмыг баримтлан зохих өөрчлөлтийг төсвийн төсөлд тусгав. Мөн яамдын дэд сайдын орон тоог цомхотгох, үүнтэй уялдуулан туслах, жолоочийн цалин, автомашин, гар утасны хэрэглээний зардлыг бууруулж төсөвт тусгав.

Мөн Улсын Их Хурлаас 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталсан Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Батлан хамгаалах болон Хил хамгаалах байгууллагуудын зарим чиг үүрэг Тагнуулын ерөнхий газарт шилжиж байгаа тул урсгал зардлыг холбогдох байгууллагуудын 2015 оны батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийхээр тусгалаа.

### **2.3.2.2. Төсвийн хөрөнгө оруулалт болон төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний талаар**

Улсын Их Хурлын 2015 оны 01 дүгээр сарын 23-нд баталсан Төсвийн тодотголоор нийт Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2015 онд санхүүжих дүнг 381.6 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд 381.6 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээнээс 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 167.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, гүйцэтгэлийн хувь 44.0 хувьтай байна.

Засгийн газрын 2015 оны хэмнэлтийн горимд шилжих тухай 230 дугаар тогтоол болон Улсын төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотойгоор Засгийн газрын 2015 оны 230 дугаар тогтоолын дагуу шинээр эхлэх 17 төсөл, арга хэмжээний 18.6 тэрбум төгрөг, болон гүйцэтгэл удаашралтай 21 ажлын 11.5 тэрбум төгрөг нийт **30.1** тэрбум төгрөгийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас бууруулахаар тооцлоо. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын өөрийн орлогоос санхүүжих 9 төсөл, арга хэмжээний 3.0 тэрбум төгрөг, мөн Архивын Ерөнхий газрын 2 дугаар байрын барилгыг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулсан нэмэлт орлогоос санхүүжихээр нэмж 2 төслийн 1.9 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг нэмж тусгалаа.

**Хүснэгт 9. Эдгээр өөрчлөлт орж байгаа төслүүдийг дор харуулбал:**

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжих дүн /тэрбум төгрөг/
<b>2015 онд батлагдсан хөрөнгө оруулалт</b>	<b>428</b>	<b>381.6</b>
Засгийн газрын 2015 оны 230 дугаар тогтоолын дагуу шинээр эхлэх ажлуудаас <u>хойшлуулсан</u>	17	-18.6
Гүйцэтгэл удаашралтай байгаа тул санхүүжилтийг 2016 онд болгон <u>хойшлуулсан</u>	21	-11.5
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын өөрийн орлогоос санхүүжихээр <u>нэмсэн</u>	9	3.03
Архивын барилга борлуулсан орлогоос санхүүжихээр <u>нэмсэн</u>	2	1.90
<b>Тодотгосон хөрөнгө оруулалт</b>	<b>422</b>	<b>356.4</b>

Харин 2015 онд Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжиж Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй Улсын Их Хурлаас батлагдсан нийт 794.6 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээнээс 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 332.3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Төсвийн тодотголоор Хөгжлийн банкны нийт 35 төсөл, арга хэмжээний 43.8 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хуулиас хасаж, 93 төсөл, арга хэмжээний 2015 онд санхүүжих дүнг 307.5 тэрбум төгрөгөөр бууруулан, 1.4 тэрбум төгрөгийн Хөгжлийн банкаар дамжин хэрэгжиж байсан 8 төсөл, арга хэмжээг хуульд нэмж, нийт **350.0 тэрбум** төгрөгийг Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтын зардлаас бууруулан 2016 оны төсөвт шилжүүлэхээр санал боловсруулсан.

**Хүснэгт 10. Өөрчлөлт оруулж байгаа төсөл, арга хэмжээний шалтгааныг харуулбал:**

ХӨГЖЛИЙН БАНКНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжих дүн /тэрбум төгрөг/
<b>2015 онд батлагдсан хөрөнгө оруулалт</b>	<b>242</b>	<b>794.6</b>
Засгийн газрын 2015 оны 230 дугаар тогтоолын дагуу шинээр эхлэх ажлуудаас <u>хойшлуулсан</u>	11	-40.3
Гүйцэтгэл удаашралтай байгаа тул санхүүжилтийг 2016 онд болгон <u>хойшлуулсан</u>	117	-311.1

Санхүүжилт <u>нэмсэн</u>	8	1.4
Тодотгосон хөрөнгө оруулалт	239	444.6

Хөрөнгө оруулалтын нийт Улсын төсөв, Хөгжлийн банкны бууруулсан дүн **380.1 тэрбум төгрөг** болж байна.

#### **2.4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТУХАЙ**

Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуулиар сангийн орлогыг 1,418.7 тэрбум төгрөгөөр баталсныг 1,222.4 тэрбум төгрөгөөр, сангийн зарлагыг 1,484.8 тэрбум төгрөгөөр баталсныг 61.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 1,546.6 тэрбум төгрөгөөр төсвийн тодотголд тусгаж байна.


Нийгмийн даатгалын сангийн орлого нийт 196.3 тэрбум төгрөгөөр бууруулж байгаад дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

- a. а) Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 2014 онд гүйцэтгэлээр нийт 151.0 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Энэ нь 2015 оны нийгмийн даатгалын сангийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл мөн хэмжээгээр буурахад нөлөөлж байна;
- b. б) Төсвийн боломж хязгаарлагдмал байгаагаас шалтгаалж төрийн албан хаагчийн цалин нэмэгдүүлэх асуудлыг хойшлуулсантай холбоотойгоор төсөвт байгууллага болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлого буурч байна.

Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тодотголд сан тус бүрд дор дурдсан өөрчлөлтийг тусгахаар тооцож төслийг боловсруулав.

**1. Тэтгэврийн даатгалын сан:** Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хүрээнд нийгмийн даатгалын байгууллага 2014 онд 12.2 мянган хүн шинээр тэтгэвэр авахаар тооцож, төсөвт тусган батлуулсан боловч тухайн жилдээ 37.7 мянган хүн, 2015 оны эхний хагас жилийн байдлаар 11.6 мянган хүн шинээр тэтгэвэр тогтоолгосон байна. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш тэтгэвэр тогтоогдсон хүний тоо төлөвлөснөөс хэтэрч байгаа үндсэн шалтгаан нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас хүрээгүй боловч олон хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд болон хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд ажиллаж байсан нөхцөлөөр иргэд шинээр тэтгэвэр тогтоолгож эхэлсэн нь нөлөөлсөн байна.

**График 9. Өндөр насны тэтгэвэр**



Хүн амын төрөлт, нас баралт, ажилгүйдлийн түвшин зэрэг хүчин зүйлсийн олон жилийн статистик болон ойрын жилүүдийн төсөөлөл дээр үндэслэж тухайн онд хэчнээн даатгуулагч шинээр тэтгэвэрт гарахыг тооцдог. Харин хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл, тухайн даатгуулагчийн төрүүлсэн хүүхдийн тоо зэрэг хүчин зүйлсийг агуулсан мэдээллийн бааз нийгмийн даатгалд байдаггүй тул эдгээр нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох иргэдийн тоог урьдчилан нарийвчлан тооцоолох боломж хязгаарлагдмал байна. Үүний улмаас ажилласан жил, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулах тухай хуулийн хүрээнд тэтгэвэр шинээр тогтоолгох иргэдийн тоо төлөвлөсөн хэмжээнээс зөрүүтэй гарахад нөлөөлсөн байна. Иймд шинээр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн бодит гүйцэтгэлд үндэслэн тэтгэврийн даатгалын сангийн зардлыг **60.3 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцов.

**2. Тэтгэмжийн даатгалын сан:** Жирэмсэн болон амаржсан эхчүүдэд олгодог тэтгэмжийн хэмжээ, нийгмийн даатгалд хамрагдах хөдөлмөрийн насны даатгуулагчид болон төрөлтийн түвшин нэмэгдэж байгаа зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж тэтгэмжийн даатгалын сангийн зардлыг **7.9** тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгох шаардлагатай байна.

**3. Ажилгүйдлийн даатгалын сан:** Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хурлаар баталсан. Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн ажлаас халагдсан шалтгааныг харгалзан 40-өөс 76 хүртэлх ажлын өдрөөр тооцож ажилгүйдлийн тэтгэмж олгодог байсныг дээрх хуулийн өөрчлөлтөөр шалтгаан харгалзахгүй 76 ажлын өдрөөр тооцож олгодог болсонтой холбоотойгоор тус сангийн зардал **5.6** тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

**4. Эрүүл мэндийн болон ҮОМШӨ-ний даатгалын сан:** 2015 оны 1-ээс 7 дугаар саруудын төсвийн гүйцэтгэлийн мэдээнд үндэслэн оны сүүлийн саруудын зардлыг тооцож



үзэхэд эрүүл мэндийн даатгалын сангийн зардлыг **9.4** тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын зардлыг **2.6** тэрбум төгрөгөөр тус тус бууруулах боломжтой байна.

## 2.5. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТУХАЙ

### 2.5.1. Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн эхний 8 сарын гүйцэтгэл, төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл

2015 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр Хүний хөгжил санд нийт 199.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 187.1 тэрбум төгрөгийн зарлагыг санхүүжүүлээ. Тус санд төвлөрсөн нийт орлогоос 23.8 тэрбум төгрөгийн орлого нь урьдчилгаа төлбөрт хаагдаж, суутган бичилтээр орлогод тооцогдсон ба тус санд 175.9 тэрбум төгрөг бэлэн мөнгөөр төвлөрсөн байна. Хүний хөгжил сан 8 дугаар сарын 31-ний байдлаар 949.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Хүний хөгжил сангийн 2015 оны орлогын төлөвлөгөө эхний 8 сарын байдлаар 11.2 тэрбум төгрөгөөр тасарч байгаагаас тус сангийн эхний 8 сарын зарлага, санхүүжилтээс 4.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн дагуу тухайн төсвийн жилдээ төлөгдөх өглөг үүсгэн санхүүжүүлээд байна.

#### Хүснэгт 11. Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл (сая төг)

	2015			Эхний 8 сар		
	Төл	Тод	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>368,864.6</b>	<b>356,932.3</b>	<b>-11,932.3</b>	<b>211,035.5</b>	<b>199,794.8</b>	<b>-11,240.7</b>
АМНАТ-ын 70 хувь	298,864.6	286,932.3	-11,932.3	211,035.5	199,743.7	-11,291.8
Ногдол ашиг	70,000.0	70,000.0	0.0			0.0
Бусад орлого					51.1	51.1
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>342,325.4</b>	<b>328,792.8</b>	<b>13,532.6</b>	<b>204,490.1</b>	<b>187,062.0</b>	<b>-17,428.1</b>
Иргэдэд олгосон бэлэн мөнгө	246,000.0	246,000.0	0.0	164,000.0	163,412.3	-587.7
Зээлийн үйлчилгээний төлбөр	79,279.5	67,415.4	-11,864.1	29,960.1	16,356.4	-13,603.7
Төр хариуцах ЭМД-ийн шимтгэл	12,040.2	12,040.2	0.0	8,027.2	7,018.8	-1,008.4
Сургалтын төлбөр			0.0			0.0
Хөрөнгө оруулалт	5,005.7	3,337.2	-1,668.5	2,502.8	274.2	-2,228.6
<b>Урсгал тэнцэл</b>	<b>31,544.9</b>	<b>31,476.7</b>	<b>-68.2</b>	<b>6,545.4</b>	<b>13,007.0</b>	<b>6,461.6</b>
<b>Нийт тэнцэл</b>	<b>26,539.2</b>	<b>28,139.5</b>	<b>1,600.3</b>	<b>6,545.4</b>	<b>12,732.8</b>	<b>6,187.4</b>
<b>Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>-26,539.2</b>	<b>-28,139.5</b>	<b>-1,600.3</b>	<b>-6,545.3</b>	<b>-12,732.8</b>	<b>-6,187.5</b>
Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	-4,500.0	17,423.4	21,923.3	20,627.5	32,620.7	11,993.2
Урьдчилгаа төлбөр	-78,260.0	-41,596.7	36,663.3	-52,172.8	-23,837.3	28,335.5
Засгийн газрын бонд	56,220.8	-3,966.2	-60,186.9	25,000.0	-25,516.2	-50,516.2
Засгийн газрын зээл			0.0		4,000.0	4,000.0

Эхний 8 сард тус санд авч ашигласан урьдчилгаа төлбөрөөс 111.5 тэрбум төгрөгийн өглөгийг Хүний хөгжил сангийн төсөвт төвлөрөх орлого 23.8 тэрбум төгрөг, улсын

төсөвт төвлөрөх орлого 87.7 тэрбум төгрөгийг суутган тооцож мөн хэмжээгээр төсөв хооронд өглөг үүсгэн бичээд байна.

## **2.5.2. Хүний хөгжил сангийн 2015 оны төсөвт хийх тодотгол**

Гадаад зах зээл дээр уул, уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ буурсан, төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2015 оны төсвийн жилд үргэлжлэн суларч байгаагаас голлон шалтгаалж Хүний хөгжил сангийн 2015 оны төсөвт дараах өөрчлөлтүүдийг хийхээр төсвийн тодотголд тусгалаа. Үүнд:

- Хүний хөгжил санд төвлөрдөг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 11.9 тэрбум төгрөгөөр бууруулах;

- Зарим бондын төлбөрүүдийг хойшлуулсантай холбоотойгоор зээлийн үйлчилгээний төлбөрийг 11.8 тэрбум төгрөгөөр бууруулах;

- Хүний хөгжил сангийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг 1.7 тэрбум төгрөгөөр бууруулах;

- Эрдэнэс Тавантолгой компанийн санхүүгийн байдлыг харгалзан тус компанид ажил үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгжүүдийн төлөх татвараас сар бүр 5 орчим тэрбум төгрөгийг хааж байна. Мөн америк долларын төгрөгтэй харьцах ханш төсөвт тусгаснаас өндөр байгаатай тул Оюутолгойн ордыг ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа төлбөрт төлөх хэмжээг нэмэгдүүлэх шаардлага үүссэн. Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн урьдчилгаа төлбөртэй холбоотой хэсэгт дараах өөрчлөлтүүдийг оруулахаар төсвийн тодотголд тусгалаа. Үүнд:

- Нийт урьдчилгаа төлбөрт хаах төсвийн орлогын хэмжээг 13.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх;

- Урьдчилгаа төлбөрт хаагдах улсын төсвийн орлого буюу урьдчилгаа төлбөрийг хаахтай холбоотой улсын төсөвт үүсгэх өглөгийн хэмжээг 50.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх;

- Хүний хөгжил сангийн 2015 онд төлөх хуваарьтай зарим бондын төлбөрүүд хойшилсонтой холбоотойгоор Засгийн газрын бондын үндсэн төлбөрт төлөх хэмжээг 90.7 тэрбум төгрөгөөр бууруулах;

Хүний хөгжил сангийн төсөвт 9-12 дугаар сарын хооронд 258.5 тэрбум төгрөгийн бондын үндсэн төлбөр, улсын төсөвт ондоо багтаан төлөх ёстой 19.7 тэрбум төгрөгийн өглөгийг 280 орчим тэрбум төгрөгийн Засгийн газрын бонд гарган санхүүжүүлэх бөгөөд бусад зарлага, санхүүжилтийг шийдвэрлэхийн тулд Эрдэнэт үйлдвэрээс төвлөрүүлэх ногдол ашгийн орлого 70.0 тэрбум төгрөгийг бүрэн төвлөрүүлэх шаардлагатай байна.

## **2.6. ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТӨСВИЙН ТЭНЦЭЛ**

Монгол Улсын 2015 оны төсвийн тодотголын дээр дурдсан өөрчлөлтүүдийг тусгахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 504.6 тэрбум төгрөгөөр буурч 6,128.0 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүн 530.3 тэрбум


төгрөгөөр бууран 7,307.2 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн нийт алдагдал 1,179.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 5.0 хувьтай тэнцэж байна.

#### Хүснэгт 12. Төсвийн тэнцэл

Үзүүлэлтүүд	2015 (тэрбум төг)		
	Төл	Тод1	Тод2
Нийт орлого ба тусламжийн дүн	7,194.35	6,662.46	6,130.32
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	7,159.97	6,632.60	6,127.98
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7,599.15	7,837.41	7,307.16
Төсвийн тэнцэл	-439.18	-1,204.81	-1,179.17
ДНБ-д эзлэх хувь	-1.8	-5.0	-5.0

---oOo---

**3.НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСӨЛ**



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага үндэслэл

Монгол Улсын нийгмийн даатгалын сангийн орлого 2015 онд нийт 196.2 тэрбум төгрөгөөр буурч байгаа бөгөөд үүнд 1-рт өмнөх жилийн орлогын төлөвлөгөө 151.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь 2015 оны нийгмийн даатгалын сангийн орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн; 2-рт төрийн албан хаагчийн цалин нэмэгдүүлэх асуудлыг хойшлуулж байгаатай холбоотойгоор төсөвт байгууллага болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлого буурахаар байна.

Нөгөөтэйгүүр тэтгэврийн сангийн зарлагыг нэмэгдүүлэх дараах шаардлагууд үүсээд байна. Үүнд:

1. “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-ийн хүрээнд нийгмийн даатгалын байгууллага 2014 онд 12.2 мянган хүн шинээр тэтгэвэр авахаар тооцож, төсөвт тусган батлуулсан боловч тухайн жилдээ 37.7 мянган хүн, 2015 оны эхний хагас жилийн байдлаар 11.6 мянган хүн шинээр тэтгэвэр тогтоолгосон байна. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш тэтгэвэр тогтоогдсон хүний тоо тооцоолсноос хэтэрсэн шалтгаан нь хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас хүрээгүй боловч тухайн үед ажилгүй байсан иргэд (дийлэнх нь олон хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд болон хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд ажиллаж байсан хүмүүс) 2015 онд олноор тэтгэвэр тогтоолгож эхэлсэн нь нөлөөлсөн байна.

2. Жирэмсэн болон амаржсан эхчүүдэд олгодог тэтгэмжийн хэмжээ, нийгмийн даатгалд хамрагдах хөдөлмөрийн насны даатгуулагчид болон төрөлтийн түвшин нэмэгдэж байгаа зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж тэтгэмжийн даатгалын сангийн зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

3. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хурлаар батлагдсан. Нийгмийн даатгалын байгууллага

даатгуулагчийн ажлаас халагдсан шалтгааныг харгалзан 40-өөс 76 хүртэлх ажлын өдрөөр тооцож ажилгүйдлийн тэтгэмж олгодог байсныг дээрх хуулийн өөрчлөлтөөр шалтгаан харгалзахгүй 76 ажлын өдрөөр тооцож олгодог болсон тул ажилгүйдлийн даатгалын сангийн зардлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай болоод байна.

Мөн 2015 оны 1-ээс 7 дугаар саруудын төсвийн гүйцэтгэлийн мэдээнд дүн шинжилгээ хийж, энэ оны сүүлийн саруудын зардлыг тооцож үзэхэд эрүүл мэндийн даатгалын сангийн зардлыг 9.4 тэрбум төгрөгөөр, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын зардлыг 2.6 тэрбум төгрөгөөр тус тус бууруулах боломжтой байна.

Дээрх нөхцөл байдлын улмаас Төсвийн тухай хуулийн 6.2.3-т “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлнэ” гэж, 34.1.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд тодотголын төслийг боловсруулна гэж заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хууль зүйн үндэслэл, шаардлага бий болсон байна.

#### **Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь нийт 3 зүйлтэй байна.

Нэгдүгээр зүйлд: Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн 3, 4 дүгээр зүйлд заасан сангийн орлого, зарлагын хязгаарыг өөрчилнө.

Хоёрдугаар зүйлд: Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан “ Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-д өөрчлөлт оруулна.

Гуравдугаар зүйлд: Хууль дагаж мөрдөх хугацааг тусгана.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар 2015 оны Нийгмийн даатгалын санд мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хуваарилж, зарцуулах эрх зүйн орчин бүрдэж хууль хэрэгжих боломжтой болно.

**Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжид бүрэн нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан хууль тогтоомжийн төслийг нэмж боловсруулах шаардлагагүй болно.

